



БАЙГАЛЬ ОРЧИН,
УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ



KFW



ГЕРМАНЫ САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Биологийн олон янз байдлыг хамгаалах,
уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл
BMZ 2012 65 511-I үе шат, BMZ 2016 67 054-II үе шат, BMZ 2018 68 272-III үе шат

Төслийн 2025 оны хагас жилийн хяналт-шинжилгээний тайлан

Төсөл
хэрэгжүүлэх
нэгж

2025 оны 06 дугаар сар

ГАРЧИГ

1. ХУРААНГҮЙ.....	1
2. ТӨСӨЛД ОРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ӨӨРЧЛӨЛТ, ТҮҮНИЙ ҮНДЭСЛЭЛ.....	19
3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ.....	5
3.1. Өнөөгийн хэрэгцээтэй тохирч буй байдал буюу хамааралтай байдал	115
3.2. Төсөл, арга хэмжээнээс хүлээгдэж байгаа үр нөлөө	115
3.3. Төсөл, арга хэмжээний зорилтын биелэлт, үр дүнтэй байдал	13
3.4. Үр дагаварт хүрч буй байдал, үйл ажиллагаануудын хэрэгжилт.....	15
3.5. Үнэлгээний зорилго, хэрэглэсэн арга зүй, сул тал	12
4. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ, ТААМАГЛАЛ БА ЭРСДЭЛ ҮҮСЭХ МАГАДЛАЛ, ТЭДГЭЭРИЙН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ.....	21
5. НИЙЦТЭЙ БАЙДАЛ БА ТОГТВОРТОЙ БАЙДАЛ.....	22
5.1. Стратегийн зорилготой нийцтэй байдал.....	22
5.2. Бодлогын орчин	23
5.3. Эдийн засаг, санхүүгийн үндэслэл	23
5.4. Байгууллагын хүчин чадал	26
5.5. Нийгэм-соёлын асуудал.....	28
5.6. Оролцоо ба өмчлөл.....	28
5.7. Жендер.....	29
5.8. Байгаль орчин.....	29
5.9. Тохиромжит технологи	30
6. ХЭРЭГЖИЛТИЙН ҮР АШГИЙН ҮНЭЛГЭЭ	31
7. ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ САНАЛУУД.....	38

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

Товчилсон үг	Тайлбар
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БОЯБ	Биологийн олон янз байдал
БОЯБХУАӨДЗ	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох
БЦГ	Байгалийн цогцолборт газар
ГСБЗБ/ KfW	Германы сэргээн босголт зээлийн банк
ДЦГ	Дархан цаазат газар
ЗБ	Зөвлөх баг
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУ	Монгол Улс
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МТ	Менежментийн төлөвлөгөө
МУАБҮ	Менежментийн үр ашигт байдлын үнэлгээ
ОБ	Орчны бүс
ОБЗЭС	Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан
УХ	Удирдах хороо
ТББ	Тендерийн бичиг баримт
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
ТХГНБХГ	Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газар
ТХБНУГ	Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газар
ТХГНУГ	Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газар
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
УТХГ	Улсын тусгай хамгаалалттай газар
УХ	Удирдах хороо
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗ	Хамгаалалтын захиргаа
СЯ	Сангийн яам
СХОХ	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Эх сурвалжууд:

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төслийн арга хэмжээний биелэлт (зорилт тус бүрээр)

Хүснэгт 2. 2025 оны он дамнасан гэрээт ажлуудын гүйцэтгэл

Хүснэгт 3. Төслийн хүрээнд 2024 онд төлөвлөсөн ХШҮ-ний ажлын хэрэгжилт
(жилийн эцсийн байдлаар)

Хүснэгт 3. Хүснэгт 3. 2025 оны үйл ажиллагаа, худалдан авах ажлын
төлөвлөгөөний дагуу ажлын даалгавар батлуулах огноо

Хүснэгт 4. Төслийн хүрээнд 2025 онд төлөвлөсөн ХШҮ-ний ажлын хэрэгжилт
(хагас жилийн байдлаар)

Хүснэгт 5. Сургалтад оролцогчдын нэрс

Хүснэгт 6. Төсөл уялдан хэрэгжих бодлогын бичиг баримтууд

Хүснэгт 7. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц орон тоо

Хүснэгт 8. Төслийг тайлагнах

Хүснэгт 9. Төслийн хэрэгжилтийн ХШҮ, төслийн үйл ажиллагааг сайжруулахад анхаарах асуудал, санал зөвлөмж

Зургийн жагсаалт

Зураг 1. Төсөл арга хэмжээнээс хүлээгдэж байгаа үр нөлөө

Зураг 2. Үнэлгээний матриц, аргачлал

Зураг 3. Төслийн санхүүжилтийн хуваарь, 2025 оны санхүүгийн төлөвлөлт

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1. Strategic Framework буюу Стратегийн Бодлого төлөвлөлт 2025-2026

Хавсралт 2. KfW банкны хөндлөнгийн үнэлгээний хурлын тэмдэглэл

Хавсралт 3. Төслийн II шатны Бүтэц орон тооны Тусгай гэрээний заалт, шийдвэр

Хавсралт 4. Мониторинг матрикс.

Хавсралт 5. БОУАӨ-ийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/365
дугаартай “Төслийн үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авах” тухай тушаал

Хавсралт 6. Төслийн 20 дахь удаагийн УХ-ны хурлын тэмдэглэл

Хавсралт 7. Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар
тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны
байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмаар
баталсан тайлангийн эх маягт

Хавсралт 8. Төслийн үйл ажиллагааны 2025 оны батлагдсан төлөвлөгөө

Хавсралт 09. Төслийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө

Хавсралт 10. Төслийн 2025 оны хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө

Хавсралт 11 Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд ХШҮ хийх үнэлгээний матриц

Хавсралт 12. Төслийн 2024 оны томилолтын төлөвлөгөө, төлөвлөгөөний
биелэлт

Хавсралт 13. Төслийн 2024 оны гэрээний хэрэгжилтийн тайлан

Хавсралт 14 Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд ХШҮ хийх үнэлгээний
матриц

1. ХУРААНГУЙ

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журмыг батлах тухай” 176 дугаар тогтоолтой холбогдуулан Сангийн сайдын 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 193 дугаар тушаалын хавсралтаар баталсан маягт 15-ын дагуу БОУАӨЯ-ны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II” төслийн 2025 оны Хяналт-шинжилгээний тайланг хагас жилийн байдлаар гаргалаа. 2025 оны хоёрдугаар улирал буюу 03 дугаар сарын 1-нээс 6 дугаар сарын 30-ны өдрийг хамарсан тайлант хугацаанд Монгол Улсын байгаль орчны бодлого, институтийн зохион байгуулалт болон эрх зүйн орчинд, өмнөх тайланд тусгагдаагүй шинэчлэл, өөрчлөлтөөс гадна онцлохуйц шинэ өөрчлөлт гараагүй болно.

2 дугаар бүлэгт төслийн хэрэгжилтийн явцад хийгдсэн хөндлөнгийн үнэлгээ, зөвлөмж, төслийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэр, тэдгээрийн биелэлт, шийдвэрлэх арга замын талаарх саналууд, мөн БОЯБХУАӨДЗТ-ийн гүйцэтгэл болон үр нөлөөг сайжруулах чиглэлээр өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

3 дугаар бүлэгт төслийн хэрэгжилтийн явц, үзүүлэлтүүдийн гүйцэтгэл, ялангуяа үр дүнгийн түвшний гүйцэтгэлд суурилсан шинэчлэгдсэн мэдээллийг танилцуулсан. Тайлант хугацаанд Үйл ажиллагааны төлөвлөгөөг (ҮАТ) 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр болон Худалдан авалтын төлөвлөгөө (ХАТ)-г мөн оны 06 дугаар сарын 20-ны өдөр баталгаажуулсан учир үйл ажиллагааны төлөвлөлтийн биелэлтийг дүгнэх боломжгүй байна. Иймд 2024-2025 онуудад он дамнаж хэрэгжсэн гэрээний биелэлтийг дүгнэлээ.

KfW банкны хүсэлтийн дагуу Зөвлөх баг төслийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний (ХШҮ) матриц, логфреймийн дагуу үр нөлөөний түвшний үзүүлэлтүүдийн гүйцэтгэлийг үнэлж, ХШҮ-ний систем болон дижитал мэдээллийн санг шинэчлэн сайжруулсан. ХШҮ системийг боловсронгуй болгохын тулд Зөвлөх багийн олон улсын болон үндэсний зөвлөхүүд Өмнөд болон Баруун бүсийн ТХГН-үүдийн харьяа 18 хамгаалалтын захиргааны 36 албан хаагчдад Power BI болон Kobo Toolbox програмуудын сургалтыг зохион байгуулсан. Дараагийн улиралд ХШҮ сургалтыг үргэлжлүүлж, төслийн нөлөөлөлд суурилсан мониторингийг судалгааг авах, мэдээллийн сангийн орчуулга, боловсруулалтын ажлыг үргэлжлүүлэхээр төлөвлөсөн. ТХН-ийн БОННМ-ийн мэргэжилтэн 2024 оны 8 дугаар сард ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш уг албан тушаал одоог хүртэл нөхөгдөөгүй байна. Энэ хугацаанд ямар нэгэн гомдол, зөрчил бүртгэгдээгүй болно. 2025 оны эхээр тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа болон цаг уурын станцын суурилуулалтын чиглэлээр сургалтууд амжилттай зохион байгуулагдсан. Говийн Их Дархан Цаазат Газар (ГИДЦГ)-ын “Б” хэсгийн барилга болон байгаль хамгаалагчийн байрны шинэчилсэн Байгаль орчны менежментийн баримт бичгүүдийг боловсруулж, KfW банкны БОННМ-ийн хариуцсан мэргэжилтэнд хүргүүлсэн. Тус баримт бичгүүд нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ болон худалдан авалтын үйл ажиллагаатай уялдуулах зохицуулалтыг нарийвчлан тусгасан бөгөөд тэдгээр нь Монгол Улсын холбогдох хууль, стандартууд болон олон улсын, ялангуяа KfW-ийн шаардлагад бүрэн нийцсэн болно.

2. ТӨСӨЛД ОРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ӨӨРЧЛӨЛТ, ТҮҮНИЙ ҮНДЭСЛЭЛ

Төсөл хэрэгжилтийн 2024-2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд санхүүжүүлэгч тал, захиалагч талуудын бодлого талуудын хөндлөнгийн үнэлгээ хийгдэж, хийх өөрчлөлт, сайжруулалтын талаар чиглэл өгсөн болно. Тэдгээрийн үндэслэл нь 2024 оны 10-11 дүгээр саруудад хийгдсэн Санхүүжүүлэгч байгууллагын хөндлөнгийн үнэлгээний тайлан, түүний зөвлөмж, 2024 оны төслийн дотоод ХШҮ-ний тайлан, зөвлөмж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хяналт үнэлгээ, дотоод аудитын газраас төслийн 2022-2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-үнэлгээний тайлан, зөвлөмж, 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Төслийн 20 дахь удаагийн удирдах хорооны хурлын шийдвэр, болон засгийн газрын 2025 оны 43 тогтоолын хавсралтаар баталсан Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалыг тус тус үндэслэсэн болно. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн, орчны өөрчлөлт, таамаглал ба эрсдэл үүсэх магадлал, тэдгээрийн төсөл, арга хэмжээнд үзүүлэх нөлөө, нийцтэй байдал ба тогтвортой байдал, хэрэгжилтийн үр ашгийн үнэлгээ, дүгнэлт болон үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж, саналуудыг тусгасан болно.

2.1 Санхүүжүүлэгч байгууллагын хөндлөнгийн үнэлгээ

БОУАӨ-ийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр баталсан удирдамжийн дагуу төслийн санхүүжүүлэгч байгууллага болох ХБНГУ-ын Сэргээн босголт зээлийн (KfW) банкны төслийн менежер Лидия Примаченкогийн ахалсан явцын үнэлгээний баг нь Монгол Улсад айлчилж, тус яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Д.Батцогт, тус банкны техникийн ахлах инженер Маттиас Бэхтолсхайм, Монгол дахь багц төслийн зохицуулагч Г.Эрдэнэбаясгалан болон төслийн зөвлөх баг болон Төсөл хэрэгжүүлэх нэгжийн төлөөллийн хамт 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 11 дүгээр сарын 02-ны өдрүүдэд төслийн хэрэгжиж буй газар нутгуудад ажиллаж явцын үнэлгээ хийсэн. Хөндлөнгийн үнэлгээний үеэр БОУАӨ-ийн сайд, тус яамны ТНБД буюу төслийн удирдах хорооны дарга, ТХГНБХГ-ын дарга буюу төслийн захирал, Сангийн яамны холбогдох удирдлага, албан тушаалтнуудтай уулзаж, төсөлд оруулах шаардлагатай өөрчлөлт бүхий доорх асуудлыг хэлэлцэж, хоёр тал хурлын тэмдэглэлээр албажуулсан болно.

2025 оны 3 дугаар сард KfW банкны хөндлөнгийн шинжээчийн оролцоотой дунд хугацааны хяналт-үнэлгээний айлчдад хийгдсэн. Хяналт-шинжилгээний үр дүнд үндэслэн БОУАӨЯ болон KfW банкны зүгээс төслийн III үе шатны дахин загварчлал, мөн IV үе шатны үзэл баримтлалыг шинээр боловсруулах хэлэлцээрийг эхлүүлсэн бөгөөд тус ажлуудтай холбоотой бүтэц, зохион байгуулалтын шинэчлэлийг дараагийн улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Дээрх дунд хугацааны үнэлгээний дүнд дараах зөвлөмжүүд өгөгдсөн Үүнд:

1. Төслийн үйл ажиллагаа урт хугацааны стратеги дээр суурилаагүй, цаашилбал, БОЯБХУАӨДЗ төслийн бодит хэрэгжилт нь Тусгай гэрээний заалттай бүрэн нийцэхгүй байна гэж үзэн нэн даруй засаж залруулах шаардлагыг үндэслэн

төслийн зөвлөх багийн-ын дэмжлэгтэйгээр стратегийн баримт бичгийг шинэчлэн бүрэлдэхүүн тус бүрийн үндсэн үйл ажиллагааг дахин боловсруулахаар хэлэлцсэн.

Хэрэгжилт: Тус чиглэлийн дагуу төслийн хэрэгжилтийн сүүлийн 2 жилийн хугацаанд мөрдөж ажиллах, 2025-2026 онуудад хэрэгжих Strategic Framework буюу Стратегийн Бодлого боловсруулж, БОУАӨЯ ба санхүүжүүлэгч талаар баталгаажуулсан. Энэ Стратегийн Бодлогод уялдуулан 2025, 2026 оны үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ. *(Хавсралт 1. Strategic Framework буюу Стратегийн Бодлого төлөвлөлт 2025-2026)*

2. ТХН-ийн орон тооны бүтцийг Тусгай гэрээний заалтын дагуу болгох төсөл хэрэгжүүлэх нэгжид мэргэжлийн удирдлага шаардлагатай байгааг
Үүнд: Тусгай гэрээнд заасны дагуу төслийн ТХН-ийн зохицуулагч болон зөвлөх багийн удирдлагыг солих, Тусгай гэрээнд байхгүй Сургалт, судалгаа, хэвлэл мэдээллийн ажилтны орон тоонд ажилтан томилохгүй байх, хуульчийг ТХН-ийн бүтцэд оруулж болох, худалдан авалтын ажилтны сул орон тоог яаралтай нөхөх шаардлагатай талаар хоёр тал санал нэгдсэн. *(Хавсралт 2. KfW банкны хөндлөнгийн үнэлгээний хурлын тэмдэглэл), (Хавсралт 3. Төслийн II шатны Бүтэц орон тооны Тусгай гэрээний заалт, шийдвэр)*

Хэрэгжилт: Тус үүрэг даалгаврын дагуу Төслийн зохицуулагчийг ТНБД-ын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн Б/06 дугаар тушаал, төслийн сургалт, судалгаа, хэвлэл мэдээллийн ажилтныг 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн Б/16, ТНБД-ын дугаар тушаалаар тус тус үүрэг ажлаас нь чөлөөлсөн.

Мөн төслийн сул орон тоонд захиалагч талаас сонгон шалгаруулалт зарлаж Төслийн зохицуулагч Н.Батдоржийг ТНБД-ын 2025 оны 01 дүгээр сарын 31- ний өдрийн Б/35 дугаар тушаал, Төслийн зохицуулагч М.Тулгыг ТНБД-ын 2025 оны 06 дүгээр сарын 03-ны өдрийн Б/162 дугаар тушаал, төслийн хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтныг ТНБД-ын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн Б/104 дугаар тушаал, төслийн худалдан авалт хариуцсан ажилтныг Сангийн сайдын ТНБД-ын 2025 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн Б/115 дугаар тушаалаар тус тус томилсон. Тус ажилтан 06 дугаар сарын 19-ны өдөр ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн. Сул орон тоог нөхөх саналыг захиалагч талд танилцуулан ажиллаж байна.

Хийгдэх ажлууд: Хоёр улсын хооронд байгуулсан Тусгай гэрээний заалтыг зөрчиж гаргасан, 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 2236/А/887 дугаартай төслийн бүтцийн тушаалыг холбогдох шийдвэрүүдийг үндэслэн шинэчлэн батлуулах, түүнтэй уялдуулан ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэн батлуулах.

3. Төслийн логфрэймийн нөлөөлөл/төслийн зорилтууд, урт хугацааны үр дүн/төслийн зорилтууд болон богино хугацааны үр дүнг тогтмол шинэчлэх шаардлагатай холбогдуулан зөвлөх багийн дэмжлэгтэйгээр одоогийн явцын тайлангийн матрицаас гадна үр дүнгийн мониторингийн матриц боловсруулсан.

Хэрэгжилт: Мониторинг матрикс суурь түвшин, хүрэх үр дүнгийн хэрэгжилт өнөөгийн төлөв байдлыг төсөл хэрэгжилт, нөлөөллийн үр дүнг тооцоолох

зорилгоор төсөлд хамрагдсан бүх талуудыг хамруулсан мониторингийн мэдээлэл, судалгааны асуумжуудыг Kobo Toolbox программаар дамжуулан авч, үр дүнг тооцоолохоор ажиллаж байна.

Хийгдэх ажлууд: Нөлөөлөл, үр дүнг үнэлэх олон талт асуумж судалгааг оролцогч талуудаас авч үр дүн боловсруулан мониторинг матрикс хүрэх үр дүнгийн эхний үнэлгээг хийх (*Хавсралт 4. Мониторинг матрикс*).

4. Тендерийн баримт бичгийг англи хэл рүү мэргэжлийн орчуулагчаар цаг тухайд нь орчуулуулах шаардлагатай байгааг онцолсон.

Хэрэгжилт: Тус тендерийн баримт бичгийг мэргэжлийн орчуулагчаар тухай орчуулах ажлыг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ч талуудаар дэмжигдээгүй учир хасагдсан болно.

Хүлээгдэж буй үр дүн: Цаашид захиалагч болон санхүүжүүлэгч талд энэ асуудлын шийдвэрлэх, санхүүгийн зохицуулалтын талаар дахин хэлэлцэнэ.

2.2 Төслийн 2022-2024 оны үйл ажиллагааны хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээ.

Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Гадаад тусламж авах, зарцуулах удирдах, бүртгэх тайлагнах журам”-ийн 17.1 дэх заалтыг үндэслэн төслийн 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, зөвлөх баг, төслийн нэгжийн албан хаагчдын хөлсөөр ажиллах гэрээний биелэлтийг үнэлэх дүгнэх ажлын хэсгийг ТНБД-ын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр А/18 дугаар тушаалаар байгуулагдсан. Тус ажлын хэсэг төслийн 2022-2024 оны үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлан, зөвлөмжийг 04 дүгээр сарын 10-ны өдөр ирүүлсэн.

Тус ХШҮ-ний ажлын дүгнэлт, зөвлөмжийн дагуу БОУАӨ-ийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/365 дугаартай “Төслийн үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авах” тухай тушаал гарсан.

Тус төслийн үйл ажиллагаанд хийсэн ХШҮ-ний ажлаар илэрсэн алдаа, зөрчилд суурилан 16 дүгнэлт, 8 сайжруулах зөвлөмж ирсэн. Ирсэн зөвлөмжийн дагуу тайлагнах, биелэлтийг хангаж тайланг дараагийн төслийн удирдах хороонд тайлагнах чиглэл ирүүлсний дагуу ажиллаж байна. Төслийн үйл ажиллагаанд хийсэн ХШҮ-тайланд суурилсан Сайдын тушаалын хүрээнд дараах ажлуудыг үүрэг болгосон болно Үүнд:

- 1.2 “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III” төслийн нэгжийн бүтцийг санхүүжүүлэгч байгууллагын саналаар шинэчлэн батлах.
- 1.3 Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах удирдах, бүртгэх тайлагнах журам”-ийн 7.2.2-д заасан “Төсөл арга хэмжээг дунд хугацаанд төлөвлөж, батлагдсан төлөвлөгөөний дагуу тогтоосон хугацаанд үр дүнтэй, бүрэн хэрэгжүүлэх”,

төслийн хэрэгжилтийг уг төлөвлөгөө, түүнд үндэслэн худалдан авах ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг хэлэлцэн батлах.

3. Төслийн ажлын үр дүнг хариуцах, төсөл арга хэмжээний төлөвлөлтийг холбогдох журамд заасны дагуу хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, биелэлтийг дүгнэж, явц үр дүнг төслийн захирал, удирдах хороонд танилцуулж ажиллахыг төслийн зохицуулагчид үүрэг болгосон.
4. Төслөөс нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний хөрөнгийн тооллогыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, өмч хөрөнгийн бүрэн бүртгэлжүүлж, ашиглалтыг сайжруулах, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газарт үүрэг болгосон.

(Хавсралт 5. БОУАӨ-ийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/365 дугаартай “Төслийн үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авах” тухай тушаал)

Хэрэгжилт:

- Сайдын тушаалын биелэлтийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн бүтцийн өөрчлөлт, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлуулахаар хэлэлцэж байна.
- Төслийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, тайлан мэдээг журмын дагуу тайлагнахад хяналт тавин ажиллаж байна.
- Төслийн үйл ажиллагааны болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг талуудад танилцуулж баталгаажуулсан.
- Төслийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн дагуу тайлбар, нэмэлт мэдээллийг төслийн зөвлөх багтай хамтран боловсруулж талуудад танилцуулахаар бэлтгэсэн.
- Төслөөс олгосон хөрөнгө бүртгэлжүүлэх ажлыг тухай бүр хүлээн авагч талтай зохион байгуулж, холбогдох шууд харьяа байгууллагад хөрөнгө бүртгэх хүсэлтийг удаа дараа хүргүүлэн ажилласан. Мөн төслийн орон нутаг болон мониторинг хариуцсан ажилтан нар хөрөнгө бүртгэл, ашиглалтад мониторинг хийж, бүртгэл судалгааг тухай бүр тайлагнан ажилладаг. Энэ жил нийт хөрөнгө орлогод бүртгээгүй үлдсэн тоног, төхөөрөмжийг хөрөнгө, орлогод бүртгэх, тухай БОУАӨ-ийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн 09/2577 дугаартай албан бичиг, тушаал гарсан. Тушаалыг, хавсралтын хамт төслийн хүрээнд санхүүжилт авсан Байгаль орчны болон бусад нийт 147 байгууллагад хүргүүлэн тайлан мэдээг нэгтгэн ажиллаж байна. Тушаалын биелэлт, хөрөнгийн бүртгэл тооцооны тайланг шат шатанд тайлагнаж ажиллана.
- Төслийн хүрээнд өгсөн хөрөнгө оруулалт тэдгээрийн ашиглалтад хяналт-мониторинг хийх ажлын төлөвлөгөөг талуудад танилцуулан батлуулсан. Тус төлөвлөгөөний дагуу 2025 оны 06 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд Дундговь аймгийн Их газрын чулууны БЦГ-т өгсөн хөрөнгө, түүний орчны бүсийн сумдад төслийн зүгээс өгсөн хөрөнгө оруулалт буюу Гурвансайхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн “Эко кабинет”, тус сумын Эрүүл

мэндийн төвд өгсөн Түргэн тусламжийн машины ашиглалт, үр нөлөөллийн мониторинг хийж ажилласан.

Хүлээгдэж буй үр дүн:

Төслийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хүрээнд хийсэн ажил, тушаалын биелэлтийг 2025 оны жилийн эцсийн тайлан, удирдах хорооны хуралд тайлагнаж ажиллана.

БОУАӨ-ийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн 09/2577 дугаартай тушаалын биелэлт, тайлан мэдээг нэгтгэн, хөрөнгийн бүртгэл тооцооны тайланг шат шатанд тайлагнаж ажиллана.

2.3 Төслийн 20 дахь удаагийн удирдах хорооны шийдвэр

Төслийн удирдах хороог шинэчлэн байгуулах тухай БОУАӨ-ийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/191 дугаартай гарсан. Төслийн санхүүжүүлэгч талын Монгол дахь төлөөлөгч, захиалагч тал болох БОУАӨЯ, Сангийн яамны харьяа газрын төлөөлөл, Төслийн зөвлөх баг, төсөл хэрэгжүүлэгч нэгж, төсөл хэрэгжиж буй газар нутаг хамгаалалтын захиргааны төлөөлөл, болон төслийн БОЯБ-ын зөвлөлийн төлөөллүүдийг багтаасан хороог байгуулсан. Тус хороо 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хуралдаж төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө, 2 шатны үнэлгээний үр дүнг, санхүүжүүлэгч талын саналуудыг хэлэлцэж дараах тогтоол, шийдвэрийг гаргасан Үүнд:

1. Төслийн захирал болон зохицуулагч нар үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг БОУАӨЯ-ны Удирдах хорооны гишүүдэд танилцуулж, 7 хоногийн дотор санал авч тусган батлуулах.
2. Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн шинэчилсэн бүтэц орон тоог хавсралт 3-т тусгасны дагуу сайдын тушаалаар батлуулах.
3. Төслийн нэгжийн шинэ бүтцээр ажиллах ажлын байрны тодорхойлолтыг батлуулан ажилтнуудад мэдэгдэл хүргүүлэх ажлыг дүгнэн хуулийн хэлтэстэй хамтран холбогдох тушаал, арга хэмжээг төлөвлөх.
4. Төслийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээний тайланг 7 хоногийн дотор орчуулан донор байгууллага, талуудад хүргүүлэх
5. Төслийн зөвлөх багийн бүтэц орон тооны шинэчлэлийг дахин хэлэлцэж батлах.

(Хавсралт 6. Төслийн 20 дахь удаагийн УХ-ны хурлын тэмдэглэл)

Хэрэгжилт:

1. Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг БОУАӨЯ-ны Удирдах хорооны гишүүдэд танилцуулж, ирүүлсэн санал зөвлөмжийг санхүүжүүлэгч талд танилцуулж, харилцан хэлэлцсэний дагуу 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан.
2. Төслийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээний тайланг 7 хоногийн дотор орчуулан донор байгууллага, талуудад хүргүүлсэн.

Хүлээгдэж буй үр дүн:

Сайдын тушаалын биелэлтийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн бүтцийн өөрчлөлт, ажлын байрны тодорхойлолтыг захиалагч талын шийдвэр гарсны дараа шинэчлэн батлуулна.

3 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ

3.1. Өнөөгийн хэрэгцээтэй тохирч буй байдал буюу хамааралтай байдал

2024 оны 09 дүгээр сарын 05-06-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсан Монгол, Германы хөгжлийн бодлогын зөвлөлдөх уулзалтын үеэр талууд хоёр улсын хөгжлийн хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл болох биологийн олон янз байдал ба байгаль хамгаалах хүрээнд цаашид хамтран ажиллах механизм, мөн хэрэгжүүлэх төслүүдийг Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулж хэрэгжүүлэхээр хэлэлцсэн Үүнд:

Төслийн II, III шат хэрэгжих Баруун болон Говийн бүсийн ТХГН-ийн биологийн олон янз байдлыг хамгаалах, ой болон бэлчээрийн тогтвортой байдлыг хангах, хамгаалалтын захиргаануудын менежментийг сайжруулах, тэдгээрийн орчны бүсийн дэд бүтэц, иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлийн хөрөнгө оруулалтууд төлөвлөгдсөн болно. Мөн төслийн 2022-2024 оны үйл ажиллагааг захиалагч тал, 2024 оны үйл ажиллагаанд санхүүжүүлэгч талын хөндлөнгийн үнэлгээ хийгдэж төслийн үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй, сайжруулах чиглэл, зөвлөмжүүдийг өгсөн. Төрийн агентлаг, яамны харьяа байгуулга зөвлөмжүүдтэй зэрэгцэн дараах бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн шинэчилсэн журмууд, төлөвлөлтүүдийг мөрдөн ажиллаж байна. Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг шинэчлэн баталсан. Тус журмын дагуу төслийн төлөвлөлт, тайлагналтын загвар маягтууд шинэчлэгдсэн. Түүнтэй уялдуулан захиалагч талд загвар, маягтуудыг танилцуулан баталгаажуулж авсан болно.

Төслийн санхүүжүүлэгч талаас төсөл хэрэгжих хугацааны Стратеги бодлого төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэн ажиллах чиглэл өгсний дагуу 5 төрлийн төлөвлөгөө, тайлангийн эх маягтыг батлуулан үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна. (Хавсралт 7. Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмаар баталсан тайлангийн эх маягт)

3.2. Төсөл арга хэмжээнээс хүлээгдэж байгаа үр нөлөө

Төслийн үндсэн баримт бичигт тусгагдсанаар төслийн үр нөлөөллийн дараах дөрвөн үндсэн шалгуур тавигдсан. Үр нөлөө нь хамгаалж буй БОЯБ-ын

тоо хэмжээний өсөлт бууралт, үйл ажиллагааны тогтвортой байдал, иргэдийн байгаль хамгааллын мэдлэг, чадварын өсөлт, судалгааны давтамж, удирдлагын боловсронгуй байдлаар илэрнэ.

Зураг 1: Төсөл арга хэмжээнээс хүлээгдэж байгаа үр нөлөө



Хэрэгжилт: Төслөөс гарах үр дүнг тодорхойлох хугацаа, нэгж, давтамж, суурь үзүүлэлт, зорилтот утга, өнөөгийн байдлын талаарх мониторингийн матриц, нэгдсэн төлөвлөгөөг зөвлөх багаас эцэслэн боловсруулж, санхүүжүүлэгчээр батлуулсан. Үр дүн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний асуумж, судалгааны хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байна.

Хүлээгдэж буй үр дүн: Төслийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх цахим асуумж судалгааг оролцогч бүх талуудаас авч, судалгааны дата боловсруулалт хийж, суурь мэдээллийн баазыг шинэчилнэ. Мөн судалгааны үр дүнд суурилан Логфрам болон мониторинг матрикс хүрэх үр дүнг шинэчлэн тайлагнана.

3.3. Төсөл арга хэмжээний зорилтын биелэлт, үр дүнтэй байдал

Төслийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг Төслийн удирдах хороонд 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр танилцуулсан. Удирдах хорооны гишүүдийн саналын дагуу захиалагч талын холбогдох газруудаас санал авах шийдвэрийн дагуу танилцуулж, санал авч нэгтгэн санхүүжүүлэгч талд хүргүүлсэн. Санхүүжүүлэгч тал буюу KfW банкнаас санал, зөвшөөрөл авч, захиалагч талд удаа дараа танилцуулж 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр баталгаажуулсан. Тус үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 47 үйл төлөвлөснөөс төслийн бүрэлдэхүүн хэсгээр авч үзвэл: Төслийн ерөнхий менежментийн 3 ажил, бүрэлдэхүүн хэсэг 1-ийн 3 ажил, 2-ын 13 ажил, 3-ын 11 ажил, 4-ийн 10 ажил, БОНМ-ийн 3 ажил, ТХН-ийн дотоод 4 ажил байна.

Нийт 47 ажлаас тогтмол төлөвлөгддөг 9 ажил, шинээр төлөвлөсөн 26 ажил, 12 ажил он дамжсан ажлууд байна.

Барилгын 4 ажил /2.04+ 2.07+3.02+ 3.04/,
Загвар төсөл 2 ажил /2.12+3.11/
Бараа нийлүүлэх 11 ажил

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх болон чадавхыг бэхжүүлэх, хэрэгцээ шаардлагын судалгаа хийх зэрэг бусад 30 ажил байна.

Хүснэгт 1: Төсөл арга хэмжээний биелэлт (зорилт тус бүрээр)

Үйл ажиллагааны зорилтууд	Үйл ажиллагааны төрөл				Ажлын тоо	Үнэлгээ Биелэлт %
	Он дамнасан	Тендер	Зөвлөхийн үйлчилгээ	Зөвлөхийн бус		
Бүрэлдэхүүн 1	2+1				3	
Бүрэлдэхүүн 2	5	5	3		13	
Бүрэлдэхүүн 3	2	7	2		11	
Бүрэлдэхүүн 4	3		6	1	10	
Ерөнхий менежмент				3	3	
БОННМ, Мониторинг				3	3	
ТХН, ЗБ-ийн дотоод ажил				4	4	
Дүн	13	12	11	11	47	

3.3.1 Үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлт

Үйл ажиллагааны төлөвлөгөө оройтож баталгаажсантай холбоотой үндсэн хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна. Он дамнаж хэрэгжсэн, 2025 оны төлөвлөгөөнд туссан 10 гэрээт ажлуудын гэрээний биелэлтийг 2025 онд хангаж, гэрээг дүгнэн ажилласан Үүнд:

(Хавсралт 8. Төслийн үйл ажиллагааны 2025 оны батлагдсан төлөвлөгөө)

Хүснэгт 2: 2025 оны он дамнасан гэрээт ажлуудын гүйцэтгэл

Но.	Гэрээт ажлын нэр	Гэрээ байгуулагдсан огноо	Гэрээ дуусах хугацаа	Гэрээний үнийн дүн	Гэрээлэгч
Гэрээт ажил амжилттай дүгнэн, хүлээн авсан, төлбөр шилжсэн ажлууд					
1.	ЮНЕСКО-ийн Хүн ба Шим мандлын хөтөлбөрт зарим тусгай хамгаалалттай газар нутгийг бүртгүүлэхэд шаардлагатай дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ №24/14	2024.01.11	2025.01.08	72,500,000 төг	Байгаль, зэрлэг амьтан хамгаалах үндэсний нийгэмлэг НҮТББ
2.	Цаг уурын автомат станцаар хангах (Говь-Алтай-2, Ховд аймаг-2) 24/399	2024.09.10	2025.02.07	432,440,000 төг	АЧСВС ХХК
3.	Аймгуудын БОАЖГ-ыг үндсэн тоног төхөөрөмжөөр хангах 24/409	2024.09.24	2025.02.21	562,576,000 төг	Ай Си Ай систем Монголиа ХХК

Гэрээт ажил амжилттай дүгнэн, хүлээн авсан, төлбөр шилжүүлэх процесс					
4.	Байгаль хамгаалагчийн сургалтын хөтөлбөрийн дагуу судалгаа, мониторингийн сургалт зохион байгуулах 24/424	2024.10.10	2025.03.09	109,500,000 төг	Дэлгэр консалтинг ХХК
5.	Хяргас нуурын БЦГ-ын (Увс аймгийн Завхан сум) орчны бүсэд бирвааз барих хэрэгцээ шаардлага, үзэл баримтлалыг боловсруулах 24/486	2024.11.28	2025.02.27	73,059,800 төг	Дөрвөн тэнхлэг ХХК
6.	Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд мэдээллийн санг стандартын дагуу байгуулах №24/174	2024.05.22	2024.08.20	69,000,000 төг	Битсофт ХХК
Гэрээт ажлын тайлан хүлээн авсан хянах процесс, гэрээ сунгалт хийгдэж буй					
7.	Говийн Их ДЦГ-ын Б хэсгийн барилгын одоогийн зураг төсөв, зардлын тооцоог шинэчлэх зөвлөх үйлчилгээ 24/19	2024.01.16	2024.05.15 2024.11.26 2025.04.01	118,810,173 төг	Бьюлдингс техноложи ХХК
8.	Байгаль хамгаалагчийн байрны барилгын нэг маягийн зураг төсөл, зардлын тооцоог боловсруулах №24/234	2024.06.04	2024.10.01 2024.12.01 2025.04.01	54,500,000 төг	Инженеринг суппорт сервис ХХК
9.	Алсын удирдлагатай камер, нарны зай хураагуурын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зөвлөх үйлчилгээ 24/389	2024.09.09	2024.12.08	60,610,000 төг	Дүйнхэр тэргүүн ХХК
Гэрээний эцсийн тайлан хүлээн авсан төлбөр шилжигдээгүй байгаа ажлууд					
10.	Аймгуудын байгаль орчин аялал жуулчлалын газруудыг дүрэмт хувцасаар хангах 24/487	2024.12.03	2025.06.01	1,964,878,958.33 төг	Асралт баян хайрхан ХХК

3.3.2 Төслийн 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт

Төслийн 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн удирдах хорооны хурлаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг танилцуулаагүй. Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө талуудын санал баталгаажсаны дараа ХАА төлөвлөгөөг батлуулсан.

Үүнд: Нийт 15 ХАА төлөвлөснөөс ангилж авч үзвэл: Ажил 3, Бараа 5, зөвлөхийн болон зөвлөхийн бус үйлчилгээ 7 байна. Нийт 15 ХАА төлөвлөснөөс 8 тендер ҮНТШ, 6 тендер ХТШ, 1 тендер LCB журмаар зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн.

(Хавсралт 09. Төслийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө)

3.4. Үр дагаварт хүрч буй байдал, үйл ажиллагаануудын хэрэгжилт

Үйл ажиллагааны төлөвлөгөө 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр захиалагч талаар баталгаажсан ба төсөл хэрэгжүүлэгч нэгж төлөвлөгөөний биелэлтийг хангуулах зорилгоор журмын дагуу ХАА-ны төлөвлөгөө, хяналт-шинжилгээний ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Мөн төлөвлөгөөний дагуу сарын ажлын төлөвлөлт, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын боловсруулалтын явцын талаар зөвлөх багтай хуралдаж, үйл ажиллагааг хурдан шуурхай төлөвлөн ажиллаж байна. Худалдан авах төлөвлөгөөний дагуу ажлын даалгавар боловсруулах ажлууд хүлээгдэж байна. Төслийн хүрээнд зөвлөх багтай хамт ажлын даалгавар боловсруулалтыг эрчимжүүлэн ажиллаж байна. Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан биелэлт, шалгуур үзүүлэлтийн дагуу ажлын даалгавар батлуулах эцсийн хугацаа нь 06 дугаар сард 1, 07 дугаар сард 8 ажил тус тус байна. Эдгээр ажлууд нь бүх нийтийн амралт болон БОУАӨЯ-ны бүтэц өөрчлөлттэй холбоотой хугацаа хэтрэх, төлөвлөсөн хугацаанд батлагдахгүй байх эрсдэлтэй байна. Төсөл хэрэгжүүлэх нэгжид тайлант хугацаанд албан ёсоор 2 ажлын даалгавар хүлээлгэн өгч, тендерийг зарлахаар бэлтгэн ажиллаж байна.

Хүснэгт 3. 2025 оны үйл ажиллагаа, худалдан авах ажлын төлөвлөгөөний дагуу ажлын даалгавар батлуулах огноо

ХААТ №	ҮАТ №	Төсөл, арга хэмжээний нэр	Худалдан авах ажиллагаанд мөрдөх хугацаа		
			Ажлын даалгавар батлуулах огноо	АД хариуцаж буй зөвлөхийн нэр	АД-баталгаажих хүлээлгэн өгөх огноо
1		2	5	7	8
Нэг. Ажил					
1	2.04, 3.02	Байгаль хамгаалагчийн эко байр 35 байр барих	2025-06	П.Оюунсайхан, Г.Гансүх	2025.06.30
2	2.07	Ховд аймгийн Алтай суманд Говийн Их ДЦГ-ын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааны цогцолбор барилга барих	2025-08	П.Оюунсайхан, Г.Гансүх	2025.08.01
3	3.04	Нөмрөгийн ДЦГ болон Дарьганга БЦГ-ын ХЗ-ны оффисын барилгын өргөтгөл	2025-08	П.Оюунсайхан, Г.Гансүх	2025.08.08
Хоёр. Бараа					
4	2.05, 3.03	Байгаль хамгаалагчийн хөдөлгөөнт хяналтын пост нийлүүлэх	2025-07	Г.Гансүх	2025.08.08
5	2.11, 3.06	ТХГН-ийн зарим ХЗ-нд алсын удирдлагатай камер болон нарны эрчим хүчний системээр хангах	2025-07	Ц.Атарболд, Г.Гансүх	2025.07.28

6	2.13, 3.09	Олон үйлдэлт трактор нийлүүлэх: (Хар-Ус нуур, Цамбагарав, болон Хан хөхийн БЦГ-уудын ОБ-ийн нөхөрлөл, хоршоонд усалгаатай ногоон тэжээлийн тариаланг дэмжих зорилгоор тоноглогдсон трактор, усалгааны төхөөрөмжөөр хангах)	2025-07	Ц.Атарболд	2025.07.08
7	3.08	Говийн Бага ДЦГ-т нарны эрчим хүчээр ажилладаг гүний худаг гаргах, хуучин 2 худгийг нарны өргүүрээр тоноглох	2025-07	Л.Алтанцэцэг	2025.07.25
8	3.10	Их богдын БЦГ-ын ОБ-ийн нөхөрлөлийг ингэний сүү боловсруулах цехийн тоног төхөөрөмжөөр хангах	2025-07	Ц.Атарболд	2025.07.31
Гурав. Үйлчилгээ					
9	2.08	ТХГН-ийн Баруун бүсийн сургалт, мэдээллийн төвийн барилгын зураг төсөл, төсөв боловсруулах	2025-10	Г.Гансүх	2025.10.31
10	2.09	Хар-Ус нуурын БЦГ-ын орчны бүсийн сумдын хог хаягдлын менежментэд дэмжлэг үзүүлэх	2025-08	Г.Гансүх, Ц.Атарболд	2025.08.29
11	2.12	Хан Хөхийн нурууны БЦГ-т ойн менежментийн чадавхыг бэхжүүлэх	2025-07	Бат-Өлзий, С.Цэндсүрэн	2025.07.04 хүлээн авсан
12	3.07	Их Газрын чулуу БЦГ болон Дарьгангын БЦГ-т Монгол тарвагыг (<i>Marmota sibirica</i>) сэргээн нутагшуулах	2025-07	н.Баттүвшин, н.Ариунцэцэг, О.Мэндбаатар	2025.07.08
13	3.11	Монгол Элсний БЦГ-т ландшафт нөхөн сэргээх	2025-07	Мандах, С.Цэндсүрэн	2025.07.04 хүлээн авсан
14	4.02	ТХГН-т шаардлагатай зарим (MNS) стандартуудыг сайжруулах	2025-08	Л.Алтанцэцэг, О.Мэндбаатар	2025.08.20
15	4.08	Байгаль хамгаалагчийн батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулах	2025-09	С.Цэндсүрэн	2025.09.19

3.4.1 Төслийн 2025 оны Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт

Төслийн санхүүжүүлэгч талын хөндлөнгийн үнэлгээ, зөвлөмж болон захиалагч талаас төслийн 2022-2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт үнэлгээний ажлын хүрээнд өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллалаа. Төслийн хүрээнд 2025 онд хяналт-шинжилгээ, үнэлгээний нийт 18 ажлыг төслийн зөвлөх багтай хамтран төлөвлөж, 2025 оны 05 дугаар сарын 20-ны батлуулсан. Төслийн цахим хуудас болон Удирдлагын мэдээллийн санд нийтэлсэн.

Хүснэгт 4: Төслийн хүрээнд 2025 онд төлөвлөсөн ХШҮ-ний ажлын хэрэгжилт (хагас жилийн байдлаар)

ХШҮ-ний ажлын чиглэл	Ажлын тоо	Үнэлгээ %
ХШҮ-ний ерөнхий менежмент	4	
Үр дүнд суурилсан ХШҮ хийх	4	
Төслийн баримт бичигт ХШҮ хийх	3	
Орон нутагт томилолтоор ажиллах	3	
Тайлан хүргүүлэх	2	
Дүн	18	

үйл ажиллагааны төлөвлөгөө 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр баталгаажсантай холбоотой хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна.

Хэрэгжилт: Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд

Төслийн үйл ажиллагааны хэрэгжилт, биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын үндсэн зорилго нь “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл”-ийн II/III үе шатны ХШҮ системийг хэрэгжүүлэхтэй, үйл ажиллагааг цаг хугацаандаа үнэн зөв, хэрэгжих хяналт тавих, зөвлөмж шаардлага тавих, зөв удирдан чиглүүлэхэд мэргэжил арга зүйн зүгээс мэдээлэл өгөх юм. Нөгөө талаас төслийн үйл ажиллагааны үр дүн, нөлөөллийг үнэлэх ажил юм. Төслийн хяналт-шинжилгээний ажлын хүрээнд жил бүр ХШҮ-ний төлөвлөгөө баталгаажуулж, түүний дагуу тайлан зөвлөмжийг өгч ажилладаг. Хоёр дахь чухал үзүүлэлт болох нөлөөлөл, үр дүнгийн үнэлгээг хийхэд 2025 оны хувьд ихээхэн анхаарч төслийн зөвлөх багтай хамтран дараах ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж байна. (Хавсралт 10. Төслийн 2025 оны хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө)

Нэг дүгээрт:

Мөн ХШҮ-ний мэдээллийн сангийн бүртгэл, ангиллыг өдөр тутамд тогтмол шинэчилж, түүний үнэн зөв байдал, уялдаа холбоо, ач холбогдлыг ханган ажиллаж байна. ХШҮ-ний үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлэх үүднээс Зөвлөх баг 2025 оны нэгдүгээр сараас эхлэн долоо хоног бүр тогтмол цахим хурлыг зохион байгуулж байгаа бөгөөд эдгээр хурлаар Power BI платформ ашиглан мониторингийн цуглуулсан мэдээлэл, өгөгдөлд дүн шинжилгээ хийх, мэдээллийг тоймлох, түүнчлэн Kobo Toolbox программаар дамжуулан төслийн нөлөөллийг тодорхойлох санал, асуулгын загварыг боловсронгуй болгох зэрэг чиглэлээр хамтран ажиллаж байна.

Хоёр дугаарт: Төслийн үйл ажиллагааны холбоотой ХШҮ-ний системийг хэрэгжүүлэхтэй холбоотой чадавх бэхжүүлэх сургалтуудыг цогц байдлаар зохион байгуулах юм. Энэ хүрээнд Олон улсын зөвлөх хатагтай Фридрика Лемме 2025 оны гуравдугаар сард Монгол Улсад хүрэлцэн ирж, дээрх сургалтуудыг Өмнөд болон Баруун бүсийн холбогдох ТХГН-ийн төлөөллийг хамруулан амжилттай зохион байгуулсан болно. ТХГН-ийн хамгаалалтын захиргааны ХШҮ хариуцсан ажилтнуудын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор зөвлөх баг сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлсэн. Энэхүү чадавхыг бэхжүүлэх сургалтыг 2025 оны гуравдугаар сарын 10–20-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд сургалтууд Өмнөд болон Баруун бүсийн төвд зохион байгуулагдаж, нийт 18 ТХГН-ийн хамгаалалтын захиргааны төлөөлөл хамрагдсан болно.

Хүснэгт 5: сургалтад оролцогчдын нэрс

Д/д	Байгууллагын нэр	Оролцогчдын тоо	ТХГН-ийн ХЗ-ны нэр, байршил
1	Говь гурван сайхны БЦГ-ын ХЗ	2	Өмнөговь аймгийн төв Даланзадгад хот
2	Өмнөговь аймгийн байгаль орчны газар	2	Өмнөговь аймгийн төв Даланзадгад хот
3	Говийн бага ДЦГ-ын ХЗ	2	Өмнөговь аймгийн Ханбогд сум
4	Их газрын чулуу БЦГ-ын ХЗ	2	Дундговь аймгийн төв Мандалговь хот
5	Дундговь аймгийн байгаль орчны газар	2	Дундговь аймгийн төв Мандалговь хот
6	Хар-Ус нуурын ТХГН-ийн ХЗ	2	Ховд аймгийн төв Ховд хот
7	Ховд аймгийн байгаль орчны газар	2	Ховд аймгийн төв Ховд хот
8	Хар нуур-Ховд голын сав газрын захиргаа	2	Ховд аймгийн төв Ховд хот
9	Ховд аймгийн УЦУОШТ	2	Ховд аймгийн төв Ховд хот
10	Ховд аймгийн СДОА	2	Ховд аймгийн төв Ховд хот
11	Мянган угалзтийн БЦГ-ын ХЗ	2	Ховд аймгийн Цэцэг сум
12	Мөнххайрханы БЦГ-ын ХЗ	2	Ховд аймгийн Мөнххайрхан сум
13	Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргаа	2	Ховд аймгийн Булган сум
14	Хөх сэрхийн нурууны ТХГН-ийн ХЗ	2	Баян-Өлгий аймгийн Дэлүүн сум
15	Монгол Алтайн нурууны ТХГН-ийн ХЗ	2	Баян-Өлгий аймгийн төв Өлгий хот
16	Баян-Өлгий аймгийн байгаль орчны газар	2	Баян-Өлгий аймгийн төв Өлгий хот
17	Баян-Өлгий аймгийн СДОА	2	Баян-Өлгий аймгийн төв Өлгий хот
18	Баян-Өлгий аймгийн УЦУОШТ	2	Баян-Өлгий аймгийн төв Өлгий хот
	Бүгд	36	

Сургалтын модуль нь ЗБ-ийн олон улсын болон үндэсний ХШҮ-ний зөвлөхүүдийн хамтарсан сургалтаар хүргэгдсэн. Тус сургалтаар дараах үндсэн сэдвүүдийн хүрээнд заасан:

- Оролцогчдод төслийн хяналт-шинжилгээний матрицын бүтэц, үр дүнгийн хүрээг танилцуулж, тэдний ойлголтыг гүнзгийрүүлэх;
- Одоогийн ХШҮ-ний мэдээллийн сангийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, мэдээллийн орхигдол, нэмж цуглуулах шаардлагатай дутуу мэдээллийг тодорхойлох;
- Мэдээлэл цуглуулах, бүлэглэх, баталгаажуулах үйл явцын тодорхой журам боловсруулж, чанарын хяналтын механизмыг оновчтой болгох;
- ХШҮ-ний үндсэн үйл ажиллагааг тусгасан дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулах, төслийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл цуглуулах ажилтнуудын үүрэг, хариуцлага (сэдэвчилсэн болон орон зайн мэдээллийн сангийн хүрээнд) болон мэдээллийг цахим мэдээллийн санд оруулах давтамжийг тодорхойлох;

- Power BI болон Kobo Toolbox ашиглан боловсруулсан интерактив хяналтын самбаруудтай оролцогчдыг танилцуулж, тэдгээрийг ашиглах аргачлалд сургах.

Оролцогчдод цахим мэдээллийн сантай ажиллах дадлага хосолсон сургалт зохион байгуулсан бөгөөд сар бүр мэдээллийг тогтмол шинэчлэхийн ач холбогдлыг онцлон тайлбарласан. Тус мэдээллийн санг ТХГН-ийн хамгаалалтын захиргааны ажилтнуудад илүү хүртээмжтэй, ойлгомжтой болгох үүднээс монгол хэлнээ орчуулж байна.

Мөн ХШҮ-ний зөвлөх баг, төсөл хэрэгжүүлэгч нэгж хамтран төслийн нөлөөллийн хяналт-шинжилгээнд ашиглах бүтцийн асуумжуудыг Kobo Toolbox платформ дээр боловсруулж, ашиглалтын туршилтыг 06 дугаар сарын 26-28 өдрүүдэд хийсэн. Ирэх тайлагналын хугацаанд судалгааг авч, үр дүнг боловсруулна.

3.5 Үнэлгээний зорилго, хэрэглэсэн арга зүй, сул тал

Төслийн үйл ажиллагааны төлөвлөлтийн биелэлтэд хяналт тавих, үнэлэх журам шинэчлэгдсэний дагуу Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6 дугаар зүйл Хяналт-шинжилгээ хийх арга, хоёрдугаар хавсралтаар баталсан “Үнэлгээ хийх журам”-ыг тус тус мөрдөж, журамд заасан арга зүйн дагуу төслийн хяналт-шинжилгээ үнэлгээний ажлыг дүгнэж ажиллаж байна.

Мөн төслийн хяналт үнэлгээний үйл явцыг сайжруулах, шалгуур үзүүлэлтийг боловсруулах зорилгоор төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх мониторинг матрицын үнэлгээний аргыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сул тал нь үнэлгээнд үр дүнгээс гадна чанарын буюу үр ашигт байдлыг тооцохгүй, зөвхөн гүйцэтгэлийг суурь болгодог тул үр ашигт байдлыг гаргаж ирэх тал дээр дутагдалтай. Үнэлгээний аргачлалыг боловсруулахдаа мөн ажлыг үе шат бүрээр нарийвчлан, үйл ажиллагааны шат дараалал бүрийг орхигдуулалгүй оруулахыг хичээж, хийгдэх ажлын тоо хэмжээ, ачаалал, зарцуулах хугацаа зэргийг харгалзан тооцож, үнэлгээнд эзлэх хувийг бодитой гаргахыг зорьсон болно. Үүнд:

Үнэлгээг хийхдээ үйл ажиллагааны үндсэн гурван чиглэлээр хийнэ.

Нэг. Төслийн худалдан авах ажиллагааны бэлтгэл ажлыг үнэлэх. Хэрэгцээ шаардлагын судалгаа, үзэл баримтлал, концепц гаргах болон техникийн тодорхойлолт, хуваарилалтын хүснэгтийг боловсруулах, ажлын даалгаврыг боловсруулах, батлуулах гэсэн үе шаттай.

Хоёр. Төслийн худалдан авах ажиллагааны явцыг үнэлэх. Худалдан авах ажиллагааны нийт 15 үе шатыг тус бүрийг тодорхойлсон тул бодит үнэлгээ гарсан гэж үзэж байна. Гэрээ байгуулснаар тус ажлыг 100% гүйцэтгэлтэй гэж үзнэ.

(Хавсралт 11 Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд ХШҮ хийх үнэлгээний матриц)

Зураг 2: Үнэлгээний матриц, аргачлал

[illegible]

4 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ, ТААМАГЛАЛ БА ЭРСДЭЛ ҮҮСЭХ МАГАДЛАЛ, ТЭДГЭЭРИЙН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

1. Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний баталгаажсан хугацааг харвал сүүлийн 3 жилд ихэвчлэн эхний улирал, болон хагас жилд захиалагч санхүүжүүлэгч талуудаар баталгаажиж байна. Энэ жил 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр захиалагч талаар баталгаажсан. Энэ нь үйл ажиллагаа төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх, он дамжих эрсдэл үүсгэж байна.
2. Төсөл хэрэгжүүлэх нэгж батлагдсан 14 ажилтны орон тооноос 9 ажилтан ажиллаж байна. Энэ нь ажлын ачаалал үүсэх, заасан чиглэл бүрд мэргэжлийн хүрээнд хүрч ажиллах боломж бүрдэхгүй байна. Мөн санхүүжүүлэгч талын саналын дагуу төсөл хэрэгжүүлэгч нэгжийн бүтцийг шинэчлэн батлах заалтын дагуу шинэчлэх шаардлагатай байна.
3. YAT-ны концепци боловсруулахын өмнө хийх ажлын саналыг суурь судалгаа, хэрэгцээ шаардлагын үндэслэл, захиалагч талуудын санал нэгдсэн албан хүсэлт зэргийг үндэслэн олон талт хэлэлцээрийн дараа баталгаажуулдаггүй. Энэ нь ажил давхардах, төлөвлөлтийг үр дүнтэй, олон нийтэд хүртээмжтэй, зорилтот бүлгүүдэд хүрэх дам нөлөөгөөр төслийн зорилго чиглэлтэй уялдсан байх боломжийг бууруулж байна.
4. Төслийн YAT-нд батлагдсан ажлуудын ажлын даалгаврыг тухайн оны эхний улирал гэхэд мэргэжлийн зөвлөх, багаар боловсруулан баталгаажуулж, хүлээлгэн өгдөг байх менежментгүй улмаас ажлын даалгавар боловсруулалттай холбоотой удаашрал нь YAT-ний хэрэгжилтийг бууруулж байна.
5. Төслийн YAT-г боловсруулахдаа шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг зааж өгсөн индикатортай уялдуулах хэрэгтэй. Энэ нь YAT-ны хэрэгжилтийг үнэлэхэд суурь зарчим болно.
6. YAT-г орсон нийт ажлуудын хуваарилалт, тоо ширхэг, хэмжээ, заасан стандартыг зөрчиж үл болох хатуу нөхцөлийг талуудад тавих хэрэгтэй. Захиалагч тал, албан тушаалтны улс төрийн шийдвэрээр 2023-2024 онд 2-4 удаагийн зөрчил гарсан. Энэ нь санхүүжүүлэгч талын санхүүжилт зогсоох эрсдэл үүсгэнэ.
7. Захиалагч талд хянуулах албан бичиг, гэрээ, санхүүжилтийн хүсэлт нь 3-21 хоног хянагддаг. Энэ нь төслийн үйл ажиллагаа удаашрах, гэрээлэгч талуудад санхүүгийн эрсдэл цаашлаад гэрээний хугацаа дуусах, дахин сунгах зэрэг эрсдэл үүсгэсэн. Иймд төслийн үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллахад бүх талаар анхаарч өгнө үү.
8. Төслийн хүрээнд хэрэгжиж буй орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих ЗЭС-ийн ашиглалт, гэрээний хэрэгжилтэд захиалагч талын хяналт сул байна. Төслийн баг хяналт тавин ажилладаг ч төсөл дууссаны дараагийн хяналт, хариуцагч талуудыг тодорхой түвшинд хүргэх хэрэгтэй байна.
9. Төслийн хүрээнд өгсөн хөрөнгө бүртгэл нь өмчийн бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгч нэгжээс 2021 хойш олон удаагийн санал, албан хүсэлт өгсний дүнд энэ онд бүртгэгдэж байна. Цаашид төслийн хөрөнгө оруулалтыг өмч хөрөнгөд бүртгэх ажлыг захиалагч, хүлээн авагч талууд хурдан шуурхай зохион байгуулж өгөх шаардлагатай.

10. Төслийн тусгай гэрээний дагуу төсөл хэрэгжүүлэхэд санхүүжүүлэгч тал болох ХБНГУ-ын ЗГ, Хамтран хэрэгжүүлэгч МУ-ын ЗГ-ын хооронд гэрээгээр хүлээсэн санхүүжилтийн үүрэг бий. Энэ гэрээний дагуу Монголын талын хөрөнгө оруулалт 2020-2025 оны хооронд маш бага хувьтай байна. Энэ нь санхүүжүүлэгч тал дараагийн шатны төсөл үй ажиллагааг төлөвлөхөд татгалзах, зогсоох эрсдэл үүсгэж байна. Иймд энэ чиглэлд анхаарах шаардлагатай байна.
11. Төсөл хэрэгжих хугацааны нийт зарцуулалт 50 хувьдаа хүрэхгүй байна. Иймээс төслийн үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна. Төслийн дуусах хугацаа 1 жил үлдсэн байна.
12. Төслийн үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу зөв зохистой ажиллаж нөхцөл боломжийг хангах шаардлагатай. Өнгөрсөн 2024 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг улс төрийн зорилгоор ашиглан орон нутгийн хяналт-мониторинг арга хэмжээг явуулаагүй байна. Энэ нь хэрэгжилтийг үнэлэх, төслийн хүрээнд өгөгдсөн хөрөнгө ашиглалт, хамгаалалтыг хянах талуудад тайлагнах ажлуудыг удаашруулсан.
13. Төслийн хүрээнд хийгдэж буй зөвлөх болон зөвлөхийн бус томоохон ажил, биологийн олон янз байдлын судалгааг БОУАӨЯ-ны ТНБД-ын тушаалаар баталсан “Биологийн олон янз байдлын зөвлөл”-өөр хэлэлцүүлэн хүлээн авч, нийтэд тайлагнадаг. Энэ зөвлөлийн гишүүд нь ОУ-ын төсөл, эрдэм шинжилгээний байгууллагуудын төлөөлөл болсон судлаачдаас бүрддэг. Эдгээр гишүүдийн цагийн ажлын урамшууллыг 2023-2025 онуудад захиалагч тал, сангийн яам олгоогүй учир дараа дараагийн зөвлөлийн хурал, үйл ажиллагааг зохион байгуулахад хүндрэл үүсэж байна. Энэ чиглэлд захиалагч буюу хамтран хэрэгжүүлэгч талууд анхаарч, шийдвэр гаргаж өгөх шаардлагатай байна.
14. Мөн ЗГ, БОУАӨЯ, ТХН-ээс бусад Тендерийн үнэлгээний хорооны гишүүд үнэлгээний хороонд ажилласан цагийн урамшуулал авах хуулийн заалттай. Төслийн хүрээнд зарласан тендерийн баримт бичгийг зарсан мөнгөн дүн нийт гишүүдийн хуульд заасан цагийн урамшуулалд хүрэлцэхгүй байна. Мөн нийт цугларсан мөнгөн дүнг захиалагч тал олгоогүй тохиолдол гарсан. Иймд төслийн үйл ажиллагааг хурдан шуурхай, хуулийн дагуу зохион байгуулж өгөх, бусад ажлын хэсгийн гишүүдийн урамшууллыг хуулийн дагуу олгож өгөхөд анхаарч өгөх хэрэгтэй.
15. Төслөөс олгосон тоног төхөөрөмжийн ашиглалттай холбоотой 2025 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар 5 удаагийн гэмтэл, эвдрэлийн мэдээлэл, засварлах албан хүсэлт төслийн нэгжид ирсэн. Иймд бараа, тоног төхөөрөмжийн тендер зарлахын өмнө ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг маш нарийн боловсруулах, мэргэжлийн зөвлөхөөр хянуулах шаардлагатай. Мөн хүлээн авч буй талуудад сургалт, өвлийн хадгалалт ашиглалтын сургалтыг сайжруулах хэрэгтэй.

5 НИЙЦТЭЙ БАЙДАЛ БА ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

5.1. Стратегийн зорилготой нийцтэй байдал

Төслийн үйл ажиллагаа нь байгаль экологийн талаар төрөөс баримталж буй дараах бодлогын баримт бичгүүдийн стратегийн зорилго, зорилттой нийцэж байгаа болно.

Хүснэгт 6: Төсөл уялдан хэрэгжих бодлогын бичиг баримтууд

д/д	Стратеги, бодлого	Бодлогын холбогдох заалт
1	“Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр” (УИХ, 1998)	“Байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцлийг хангах, байгалийн баялгийг арвижуулах, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах зорилгоор байгалийн бүс бүслүүрийн үндсэн шинж, иж бүрдлийг төлөөлсөн экологийн онцгой ач холбогдол бүхий газар нутгаар тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, нийт нутаг дэвсгэрийн 30-аас доошгүй хувьд хүргэнэ”
2	Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр	2030 он гэхэд экосистемийн үндсэн төлөөлөл тус бүрийн 30-аас доошгүй хувь, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өвөрмөц экосистемийг бүхэлд нь тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулж, менежментийг нь сайжруулах, 2020 он гэхэд ТХГН-ийн хамгаалалтын захиргааны дэд бүтцийг сайжруулан, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлсэн байна. 2025 он гэхэд Биологийн олон янз байдлын талаарх шалгуур үзүүлэлтийг Үндэсний тооцооны системд нэвтрүүлж, холбогдох салбарын хөтөлбөрийн мониторинг үнэлгээний системд тусгах
3	Алсын хараа 2050 (ЗГ, 2019)	Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем 6.1.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохистой менежментийг хэрэгжүүлнэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем 6.1.2. Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг улсын хэмжээнд үе шаттай хийж нөөцийн өөрчлөлтийг шинэчлэн тогтоож, зохистой менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. 6.2.2. Амьтан, ургамлын улаан дансыг шинэчлэх, шинээр бий болгож, ховордсон зүйлийн хамгааллын арга замыг тодорхойлж хэрэгжүүлнэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил 1.1.25.Сурах бичиг, сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн, цахим болон зайн сургалтын хүртээмжийг нэмэгдүүлж, суралцагчдын ялгаатай хэрэгцээг хангасан байхаар боловсруулж, түгээнэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил- Шинжлэх ухаан, инновац 2.4.12. Судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд суурилсан шагнал, урамшууллын тогтолцоог бий болгоно. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд ээлтэй амьдрах орчин 2.5.2. Орон сууцны чанар, стандартыг ханган, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлнэ. 2.5.4. Орон сууцны халаалт, эрчим хүчний эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.

		2.5.6. Ногоон байгууламжийн усалгаанд хур тунадасны болон саарал усыг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Гэр бүл 2.3.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг тогтмол нэмэгдүүлнэ. 2.4.10. Аж үйлдвэрийн тэргүүлэх салбарт дэвшилтэт болон шинэ технологи, бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгосон, нэвтрүүлсэн, нутагшуулсан аж ахуйн нэгжийг гааль, татвар, зээлийн бодлогоор дэмжинэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Амьдралын чанар ба дундаж давхарга-Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес 3.3.15. Гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлнэ. /хурдасгуур хөтөлбөр, менторшип, co-work-ing space, түрээсийн хөнгөлөлт/ Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Амьдралын чанар ба дундаж давхарга - Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт 3.4.2. Барьцаа хөрөнгийн, зээл авах хүсэлтэй бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд Засгийн газрын зүгээс санхүүжилтийн баталгаа гаргах үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд ээлтэй амьдрах орчин 2.5.20. Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулах, хүнсний сүлжээний бүх шатанд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хүнсний салбарын стандартуудыг олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартад хүргэхэд чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлнэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хөдөлмөрийн зах зээл 2.6.15. Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хүн амын аюулгүй байдлыг хангах болон мэргэжлийн өндөр ур чадвар, технологийг хөдөлмөрийн зах зээлд нутагшуулах бодлоготой уялдуулна.
--	--	---

5.2 Бодлогын орчин

Монгол орны байгалийн олон төрлийн бүс, бүслүүр нь зэрлэг амьтан, ургамлын олон төрөл зүйлийн амьдрах орчныг бүрдүүлж байдаг. Эдгээр биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээ нь Монгол улсын нийгэм, эдийн засаг, соёлын болон хөгжлийн үндэс нь юм. Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015-2025)-т ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалан хамгаалах зорилгоор 2030 он гэхэд хамгаалах шаардлагатай экологийн хувьд чухал ач холбогдолтой 215 газраас 63 байршлын 15,3 сая га газрыг улсын тусгай хамгаалалтад авч, ТХГН-ийн хэмжээг 30 хувьд хүргэнэ гэж заасан.

ТХГН-ийн сүлжээг хариуцсан агентлаг байгуулж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх тухай санал 2024 оны 06 дугаар сард захиалагч талаас гарсан. Энэ тохиолдолд Монгол Улсын ТХГН-ийн сүлжээний менежментийн бодлогыг боловсруулахад мэргэжлийн зөвлөгөө шаардлагатай болно. Тиймээс төслийн зорилтот бус нутгуудад бүрэлдэхүүн хэсэг, шалгуур үзүүлэлт зорилтын дагуу төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд ТХГН-ын менежментийг дэмжих, сүлжээг бэхжүүлэх үндсэн зорилготой уялдуулан ажиллаж байна.

5.3 Эдийн засаг, санхүүгийн үндэслэл

Төслийн II, III шат 2020-2027 онуудад нийт 27,5 сая еврогийн санхүүжилттэйгээр хэрэгжихээс 2024 оны жилийн эцсийн байдлаар 37 орчим хувь нь зарцуулагдсан байна. Нийт санхүүжилтийн үлдэгдэл 17.4 сая еврог төслийн үлдэгдэл хугацаа 2025-2027 онуудад зарцуулахаар тооцоолбол нэг жилд 5,8 сая орчим евро зарцуулахаар төлөвлөгдөхөөр байна.


Төслийн II, III шатны санхүүжилтийн төлөв: 27.5 сая.евро

ХБНГУ-ын ЗГ-аас төслийн 2-р үе шатны хүрээнд үзүүлэх санхүүгийн буцалтгүй тусламж - 19.5 сая евро

ХБНГУ-ын ЗГ-аас төслийн 3-р үе шатны хүрээнд үзүүлэх санхүүгийн буцалтгүй тусламж - 8 сая евро

МУ-ын ЗГ-аас 2, 3-р үе шатны хүрээнд хүлээсэн үүрэг - 14.8 тэрбум төгрөг. Төсөл хэрэгжилтийн явцын санхүүжилтийг харвал 4.8 тэр бум төгрөг буюу нийт засгийн газрын хүлээсэн үүргийн 50 хувьд хүрэхгүй байна. Иймд Монгол улсын засгийн газрын хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх, хэлэлцэх шаардлагатай байна.

Зураг 3.: Төслийн санхүүжилтийн хуваарь, 2025 оны санхүүгийн төлөвлөлт
(ХБНГУ-ЫН ЗГ-ЫН САНХҮҮЖИЛТ, ГҮЙЦЭТГЭЛ /САЯ ЕВРО/)



5.4 Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хүчин чадал

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн бүтэц орон тоо нь хоёр улсын засгийн газар хоорондын хэлэлцээрээр байгуулсан тусгай гэрээ түүний заалтын дагуу ажиллах ёстой. Өнөөгийн байдлаар ТХН нь 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн БОУАӨ, Сангийн сайдын хамтран 236 А/ 837 дугаартай тушаалын дагуу 14 ажилтны орон тоотойгоор баталсан. Тайлант оны хугацаанд 9 ажилтан ажиллаж байна.

Хүснэгт 7. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц орон тоо

Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаал 2020.05.27 115А/405		Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаал 2022.03.31 71А/82		Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаал 2024.12.24 236А/887	
Төслийн зохицуулагч	1	Төслийн зохицуулагч	1	Төслийн зохицуулагч	1
Санхүүгийн ажилтан	2	Санхүүгийн ажилтан	1	Санхүүгийн ажилтан	1
Худалдан авалт хариуцсан ажилтан	3	Худалдан авалт хариуцсан ажилтан	3	Худалдан авалт хариуцсан ажилтан	2
Байгаль орчин нийгмийн менежментийн ажилтан	1	Байгаль орчин нийгмийн менежментийн ажилтан	1	Байгаль орчин нийгмийн менежментийн ажилтан	1
Хяналт-мониторинг хариуцсан ажилтан	1	Хяналт-мониторинг хариуцсан ажилтан	1	Хяналт-мониторинг хариуцсан ажилтан	1

Хуулийн ажилтан	1	Хуулийн ажилтан	1	Захиргааны ажилтан	1
	-	Гэрээ хариуцсан ажилтан	1	Гэрээ хариуцсан ажилтан	1
Захиргааны ажилтан	1	Захиргааны ажилтан	1	Сургалт, мэдээлэл хариуцсан ажилтан	1
Орон нутгийн ажилтан	2	Орон нутгийн ажилтан	2	Барилгын зөвлөх ажилтан	1
Жолооч	2	Жолооч	2	Олон нийттэй харилцах ажилтан	2
			-	Жолооч	2
Нийт	14	Нийт	14	Нийт	14

Тайлангийн хугацаанд ТХН-ийн бүтэц орон тооны хувьд дараах асуудлууд зөрчилтэй байсан. Хуулийн ажилтны гэрээ 2022 оны 12 сараар дуусгавар болсон ч 2023-2025 оны хагас жилийн байдлаар хуулийн ажилтангүй ажилласан. Хуулийн ажилтан нь төслийн баримт бичиг, гэрээ тайлан зэрэг ажлуудад хууль эрх зүйн дэмжлэг үзүүлдэг учир нэн шаардлагатай байна.

Санхүүжүүлэгч талаас ирүүлсэн санал, төслийн удирдах хорооны шийдвэрийн дагуу төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтцийн шинэчилсэн хуваарийг баталгаажуулахаар ажиллаж байна.

Хүснэгт 8: Төсөл хэрэгжүүлэх нэгжийн шинэчилсэн бүтэц, орон тоо

№	Албан тушаал	Орон тоо
1.	Төслийн зохицуулагч	1
2.	Санхүүгийн ажилтан	1
3.	Худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтан	1
4.	Худалдан авалт, байгаль орчин, нийгмийн менежмент хариуцсан ажилтан	1
5.	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтан	1
6.	Гэрээ хариусан хуулийн ажилтан	1
7.	Орон нутгийн ажилтан (Говийн бүсийн орон нутгийн Тусгай хамгаалалттай гаруудын үйл ажиллагаа, бодлого, сургалт, судалгаа хариуцсан)	1
8.	Орон нутгийн ажилтан (Баруун бүсийн орон нутгийн Тусгай хамгаалалттай гаруудын үйл ажиллагаа, бодлого, сургалт, судалгаа хариуцсан)	1
9.	Орчуулагч, Захиргааны ажилтан	1
10.	Жолооч	1
Нийт		10

5.5. Нийгэм-соёлын асуудал

Төслийн хэрэгжиж буй газар нутгийн хувьд баруун болон говийн бүс нутгийн аймгуудыг хамарч байна. Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүс дэх амьдарч буй бүх л нийгмийн давхаргыг хамарч, ямар нэг байдлаар иргэдийн зан заншил, соёлоор ялгаварлах үзэлгүйгээр тэгш хүртээмжтэй үр дүнг бий болгох нь баримтлах зарчмуудын нэг. Төслийн II, III шатны хүрээнд ТХГ-ын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих санхүүгийн арга хэмжээг зохион байгуулахаар ажиллаж байна. Мөн дээр нь орчны бүсийн сумдын иргэдийн боловсролын болон эрүүл мэндийн салбарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хөрөнгө оруулалтын туслалцаа үзүүлэн ажиллаа. Үүнд: Тусгай хамгаалалттай газар нутгийн Орчны бүсийн сумдын сургуулийн эко кабинет байгуулах тавилга, компьютер, тоног төхөөрөмжөөр хангах, орчны бүсийн сумдыг эмнэлгийн түргэн тусламжийн машинаар хангах зэрэг ажлууд болно.

5.6. Оролцоо ба өмчлөл

5.6.1 Төслийн хамтын оролцоо, хамтын ажиллагаа

Төслийн зорилго нь Монгол орны баруун ба баруун өмнөд бүсийн ТХГН болон орчны бүс нутгийг сонгож, экологийн коридор нутгийн тогтвортой, үр дүнтэй менежментийг бэхжүүлэх, нутгийн ард иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд оршино. Энэ зорилгын хүрээнд төсөл хэрэгжиж буй аймгуудын ТХНГ-ын хамгаалалтын захиргаад, аймгийн ЗДТГ, БОУАӨГ, УЦУОШГ, Ойн ангиуд, Онцгой байдлын газар, цаашлаад орон нутгийн байгууллагууд, орон нутгийн иргэдтэй төслийн зорилтот үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж байна.

Байгаль орчны салбарт хандивлагчдын дэмжлэгтэй 20 төсөл хэрэгжиж байгаа бөгөөд тэдгээр байгууллагуудтай тодорхой зорилтот бүсүүдийн хүрээнд хамтран ажилладаг. Тайлангийн хугацаанд төсөл нь WWF, SPACES, ITG, ENSURE төслүүдтэй дараах чиглэлээр хамтран ажилладаг.

- Говийн Их "Б" ДЦГ-ын хамгаалалтын захиргааны байрны барилгын хүрээнд ITG-тэй хамтран ажиллаж байна.
- WWF, ITG, TNC-ийн дэмжлэгтэйгээр ТХГН-ийн удирдлагын менежмент, ТХГН-уудын менежментийн төлөвлөлтийг сайжруулах,
- SPACES бүхий ТХГН-ийн хамгаалалтын бүсэд хог хаягдлын менежментийн хэрэгцээг үнэлэх,
- GIZ-тэй жижиг зээл зээлдэгчийн туршлага солилцох,
- SPACES-ийн STREAM бүрэлдэхүүн хэсэгтэй зэрэгцэн ойн ангиудыг тоног төхөөрөмжөөр дэмжих,
- Орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих ажлын хүрээнд бяслагийн үйлдвэрийн анхны ТЭЗҮ-ийг GIZ-тэй хамтран боловсруулах
- Байгаль хамгаалагч бэлтгэх арга барилыг GIZ-тэй хамтрахаар төлөвлөсөн зэрэг хамтын ажиллагаатай ажиллаж байна.

5.6.2 Өмчлөл

Аливаа нэгэн техникийн туслалцаа үзүүлж байгаа нь цаанаа тухайн үйл ажиллагааг цаашид тогтвортой байдлыг бий болгох, суурь үр дүнг сайжруулах

зорилготой байдаг. Төслийн хүрээнд оруулсан хөрөнгө оруулалтын үр дүнг нэмэгдүүлэхэд өмчлөлийн асуудал маш чухал. Нийлүүлсэн эд хөрөнгийг хөрөнгийг бүртгэх, ашиглах, тайлагнах, хяналт тавих, хариуцлага тооцох болон бусад харилцааг “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах” Сангийн сайдын 131 тоот журмын дагуу холбогдох төрийн захиргааны төв байгууллага хариуцан ажиллаж байна. Өнгөрсөн жилүүдэд төслийн зүгээс ТХГН-ууд хамгаалалтын захиргаад болон ТХГН-ын орчны бүсийн байгаль орчны болон бусад байгууллагуудад менежментийн төлөвлөгөөнд тусгасан нэн шаардлагатай тоног төхөөрөмж, авто машин, хээрийн болон үндсэн судалгааны багаж хэрэгсэл, оффис тавилга хэрэгсэл хангасан. Төслийн зүгээс олгосон хөрөнгө бүртгэлийг жил бүр төсөл хэрэгжүүлэгч нэгж, захиалагч тал хамтран хяналт тавьж ажилладаг бөгөөд 2025 оны эхний улирлын байдлаарх хөрөнгө бүртгэлийн судалгаа хийгдэж нийт хөрөнгө орлогод бүртгээгүй үлдсэн тоног, төхөөрөмжийг хөрөнгө, орлогод бүртгэх, тухай БОУАӨ-ийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн 09/2577 дугаартай албан бичиг, тушаал гарсан. Тушаалыг, хавсралтын хамт төслийн хүрээнд санхүүжилт авсан Байгаль орчны болон бусад нийт 147 байгууллагад хүргүүлэн тайлан мэдээг нэгтгэн ажиллаж байна.

5.7. Жендер

Төслийн зорилго нь Монгол орны баруун ба баруун өмнөд бүсийн ТХГН болон орчны бүс нутгийг сонгож, экологийн коридор нутгийн тогтвортой, үр дүнтэй менежментийг бэхжүүлэх, нутгийн ард иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд оршино. Төслийн зорилтот үйл ажиллагааны хүрээнд байгаль орчны салбарт ажиллаж буй эмэгтэй, эрэгтэй ажилчдын ажиллах орчин нөхцөлийг хангах зорилгоор, дулаан хувцас хэрэгслийг нийлүүлэхдээ жендерийн эрх тэгш байдлыг хангах зорилт тавин ажилладаг. Мөн төслийн хүрээнд орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих ажлуудыг төлөвлөхдөө жендерт мэдрэмжтэй, эрх тэгш хандах үндсэн шалгуурыг тавьж ажилладаг. Төслийн үйл ажиллагааны үр дүнгийн суурь судалгааны асуумжуудыг боловсруулж байгаа бөгөөд тус асуумж судалгаанд жендерийн эрх тэгш байдлын талаарх гарсан үр дүнг нарийн тусган танилцуулна.

5.8. Байгаль орчин

ТХН-ийн Байгаль орчин, нийгмийн менежментийн ажилтан 2024 оны 8 дугаар сард ажлаас гарснаас хойш холбогдох орон тоо өнөөг хүртэл нөхөгдөөгүй байна. БОНМ-тэй холбоотой аливаа үйл ажиллагааг зөвлөх багийн чиглэлийн зөвлөх хариуцсан ажиллаж байна. Тайлант хугацаанд төслийн албан ёсны цахим хуудсанд (<https://bassr.mn/feedback>) байршуулсан санал, гомдол хүлээн авах хэсгээр аливаа гомдол, санал хүсэлт бүртгэгдээгүй болно. Тайлангийн хугацаанд БОНМ-тэй холбоотой доорх үйл ажиллагааг зөвлөх баг хэрэгжүүлсэн.

Үүнд: Эрээн нуурыг нөхөн сэргээх ажил нь Монгол Улсын Засгийн газраас санхүүжүүлснээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар нь барилгын ажлын гэрээ байгуулж, биологийн төрөл зүйл, сөрөг нөлөөг бууруулах стратегийн чиглэлээр дэмжлэг хүссэний дагуу БОНМ-ийн үнэлгээг хийхэд төслийн зүгээс дэмжлэг үзүүлж ажилласан.

БОНМ-ийн чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа

2025 оны 2 дугаар сарын 3-нд “Ай Си Ай Систем Монголиа” ХХК-аас үндсэн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны сургалтыг 16 аймгийн Байгаль орчны газрын ажилчдад амжилттай зохион байгуулсан.

Мөн 2025 оны 1 дүгээр сард автомат цаг уурын станцын нийлүүлэлтийн дараагаар “AchCVC” ХХК-аас УЦУОШТ-ийн инженер, техникчдэд зориулан угсралт, ашиглалт, засвар үйлчилгээний талаар онол, дадлага хосолсон сургалтыг зохион байгуулсан. Түүнчлэн, 2025 оны 4 дүгээр сард Ховд аймагт хоёр нэмэлт станц суурилуулах үеэр практик сургалтыг газар дээр нь зохион байгуулсан.

БОНМ – ГИДЦГ-ын Б хэсгийн хамгаалалтын захиргааны барилга

Анхны зураг төсөвт үндэслэсэн ss-ESMP төлөвлөгөөг 2023 онд KfW албан ёсоор баталсан. Гэсэн хэдий ч зураг төсөлд орсон өөрчлөлтүүдийн дагуу уг баримт бичгийг шинэчлэн боловсруулж, дахин KfW-д батлуулахаар хүргүүлсэн. Үнэлгээний үр дүнгээр уг хөрөнгө оруулалт нь байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөлөл багатай гэж дүгнэгдсэн. Шинэчилсэн ss-ESMP-д барилгын үеийн эрсдэлийг бууруулах тусгайлсан арга хэмжээнүүдийг тусгасан бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэх явцад KfW-ийн шаардлага болон Монгол Улсын холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтыг чанд мөрдөх нь нэн чухал байна.

Байгаль хамгаалагчийн байрны БОНМ-ийн асуудал

Төслийн Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээ баримт бичигт үндэслэн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны дүрэм (БОНҮАД) боловсруулагдсан. Байгаль хамгаалагчийн барилга нь цар хүрээний хувьд хязгаарлагдмал, хүн ам суурьшаагүй бүсэд байрлаж буй тул зарим заалтыг зохих ёсоор хассан болно. БОНҮАД батлагдсаны дараагаар уг баримт бичгийг төслийн зураг төсөл болон худалдан авалтын холбогдох баримт бичгүүдэд нэгтгэн тусгах бөгөөд хэрэв KfW-ийн худалдан авалтын стандарт загварыг ашиглаж буй бол БОНҮАД нь Байгаль орчин, нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлын техникийн тодорхойлолтын “В хүснэгт”-ийг орлох зориулалттай. Харин үндэсний худалдан авалтын журам мөрдөгдөж буй нөхцөлд БОНҮАД нь Монгол Улсын холбогдох эрх зүйн зохицуулалтад нийцүүлэн уялдуулж, өөрчлөгдөнө. Мөн газар ашиглалт болон байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (ESIA)-тэй холбоотой асуудлуудыг тодорхой болгох үүднээс Байгаль орчин, нийгмийн менежментийн баг БОУАӨЯ-тай нягт хамтран ажиллаж байна.

5.9. Тохиромжит технологи

Төслийн хүрээнд хийгдэх хөрөнгө оруулалт шууд болон шууд бусаар хүрээлэн буй орчиндоо эерэг нөлөө үзүүлэх чиглэлийг баримталж ажилладаг. Энэ нь нэг талаараа мэргэжлийн байгууллагуудын судалгаа шинжилгээ, мониторингийн ажилд дэмжлэг үзүүлж, боловсон хүчний чадавх, ажиллах орчныг сайжруулах, нөгөө талаар орчны бүс дэх иргэдийн амьжиргааг дэмжих, байгаль орчинд ээлтэй бизнесийг дэмжихэд анхаарч ажилладаг. Төслийн хүрээнд зорилтот бүс нутагт буй

УТХГ, тэдгээрийн орчны бүсийн байгууллагуудын менежментийг дэмжих, сүлжээг бэхжүүлэх зорилго бүхий 4 үндсэн бүрэлдэхүүнт арга хэмжээг тухайн бүс нутгийн онцлогт тулгуурлан урьдчилан судалгаа хийж, санал зөвлөмжид тулгуурлан байгаль орчинд ээлтэй, биологийн олон янз байдлыг хамгаалсан, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад нөлөөлөл үзүүлэх тохиромжит технологийг чухалчлан сонгож, төлөвлөн хэрэгжүүлдэг.

6. ХЭРЭГЖИЛТИЙН ҮР АШГИЙН ҮНЭЛГЭЭ

6.1 Хэрэгжилтийн үр ашгийн үнэлгээ- суурь үнэлгээ

Төслийн үйл ажиллагаа, үр ашгийн үнэлгээг үнэлэх зорилгоор төслийн Логфрам болон Мониторинг матрикс боловсруулан талуудад танилцуулж баталгаажуулсан. Төсөл эхлэхийн өмнө хийсэн суурь судалгааны өгөгдөлд үндэслэн төслийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг тодорхойлох, үнэлэх арга зүйн дагуу дунд шатны үнэлгээний арга зүй, судалгааны асуумж, хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байна. Дараа жил төслийн дуусах хугацаанд эцсийн үр дүнгийн үнэлгээг хийхээр бэлтгэн ажиллаж байна.

6.2 Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ, тайлагналт

Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын тусламж авах, зарцуулах удирдах, бүртгэх тайлагнах журам"-ын холбогдох зүйл заалтууд, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 43 дугаар тогтоол "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, тайлагналт", түүний хавсралтуудад заасан журмын дагуу төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үр ашгийн үнэлж, үр дүнг жил бүр дараах байдлаар тайлагнаж ажилладаг. Үүнд:

- УХ-ны хурал (жилд 1-2 удаа);
- ТХН-ийн явцын мониторингийн үнэлгээ (үйл ажиллагаа тус бүрээр)
- Аудитын үнэлгээ (жилд 1 удаа);
- Дунд хугацааны үнэлгээ (улирал тутам);
- ГСБЗБ-ны явцын үнэлгээ (жилд 1 удаа);
- ГСБЗБ-ны явцын үнэлгээний протоколын биелэлт (хагас жил тутам)
- Төслийн үйл ажиллагааны тайлан (БОАЖЯ-ны УАӨГ, ГХАГ-т хагас жил тутам)
- Төслийн худалдан авах ажиллагааны тайлан (БОАЖЯ-ны НХБЗГ-т хагас жил тутам)
- Төслийн хяналт, шинжилгээний тайлан (СЯ-нд жил тутам)
- Төсөл хэрэгжилтийн тайлан (ГСБЗБ-нд хагас жил тутам, ЭКО КОНСАЛТ Зөвлөх компанид улирал тутам)
- Шилэн дансны тайлан мэдээ (сар тутам)
- Үр дүнд суурилсан Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлагын мэдээллийн нэгдсэн сан (ODAMIS)-гийн мэдээ (тухай бүрд)

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III төслийн жилийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 2022 онд 82 хувь, 2023 онд 75 хувь, болон 2024 онд 65.7 хувьтай байна. Энэ нь төслийн

захиалагч болон санхүүжүүлэгч талуудын шийдвэр, ажлын даалгавар боловсруулалт, баталгаажуулалт зэрэг дотоод болон гадаад олон хүчин зүйлээс шалтгаалан хэрэгжилт удаашрах, дамнан хэрэгжих, болон цуцлагдах шалтгаан болж байна.

Хүснэгт 8: Төслийг тайлагнах

Гадаадын тусламжийн төсөл, арга хэмжээг тайлагнах					
№	Тайлангийн төрөл	Журам	Хариуцах ажилтан	Хугацаа	Хэнд хүргүүлэх
1	Үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан	Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Тусгай гэрээнд заасны дагуу	Зөвлөх баг	Улирал тутам	Германы Сэргээн босголт зээлийн банк (KfW)
2	Үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан	Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 43 дугаар тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, тайлагналт” хийх нийтлэг журам”-ын дагуу	Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан	Хагас жил тутам	БОУАӨЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газар
3	Худалдан авалтын төлөвлөгөө, тайлан	Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 363 дугаар тушаалаар баталсан “ТБОНӨХБАҮХАА-г төлөвлөх, тайлагнах журам”	Худалдан авах ажиллагааны ажилтан нар	Сар тутам	БОУАӨЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс
4	Санхүүгийн үйл ажиллагааны тайлан	Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалын хавсралт	Санхүүгийн ажилтан	Хагас жил тутам	Сангийн яаманд
5	Хяналт, шинжилгээний тайлан, төлөвлөгөө	МУ-ын ЗГ-ын 2016 оны “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журмыг батлах тухай” 176 дугаар тогтоол, Сангийн сайдын 2016 оны 193 дугаар тушаалын хавсралт маягт-15	Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан	Тухай бүр	Удирдах хорооны хурлаар танилцуулна Үр дүнд суурилсан ХШҮ-ний удирдлагын мэдээллийн нэгдсэн санд байршуулна
6	Ашиглалтын тайлан мэдээ НӨАТ-ын тайлан НД-ын шимтгэлийн тайлан ХАОАТ-ын тайланг		Санхүүгийн ажилтан	Сар бүр	БОУАӨЯ, СЯ баталгаажуулан KfW банканд
					Татварын ерөнхий газарт
					ХУД-ийн НД-ын хэлтэс, татварын хэлтэст

6.2 Эрсдэл үүсэх магадлал, зөрчил, зөвлөмжийн биелэлт

Төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор 2024 оны жилийн эцсийн тайланд зөвлөмжөөр өгөгдсөн эрсдэл, зөрчлийн мэдээллийг хавсаргасан. Тус ажлууд нь тайлант хугацаанд биелэгдээгүй учир дахин анхааруулах зорилгоор танилцуулж байна (*хүснэгт 9*). Төслийн хяналт-шинжилгээ, мониторингийн 2025 оны төлөвлөгөөнд өмнөх онд өгөгдсөн сайжруулах, эрсдэлээс сэргийлэх, зөрчлийг арилгах ажлуудыг тусгасан. Зөвлөмжийн биелэлтийг жилийн эцсийн удирдах хорооны хуралд танилцуулан ажиллана.

Хүснэгт 9: Төслийн хэрэгжилтийн ХШҮ, төслийн үйл ажиллагааг сайжруулахад анхаарах асуудал, санал зөвлөмж

Төслийн үндсэн бичиг баримт болох Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, БОАЖЯ, СЯ, KfW банк хооронд 2019.06.26-ны өдөр байгуулсан Тусгай гэрээ болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах” журмын заалтыг мөрдөн ажиллах тухай					
№	Зөрчил, авах арга хэмжээ	Тайлбар, тодруулга	Холбогдох бичиг баримт, мэдээлэл	Хавсралтын жагсаалт	Эх сурвалж
	ТХН-ийн ажилчдын цалинг буруу тогтоосон. Авах арга хэмжээ: Цалингийн тооцооллыг шалгах, Сангийн ямаар хянуулах, шинэчлэн тогтоох, илүү авч байсан мөнгийг улсад буцаан төлүүлэх, улсыг хохиролгүй болгох	- Захиргааны ажилтны үндсэн цалинг 4 саяар тооцсоноос гадна ямар ч төсөл дээр ажиллаагүй байхад 3 төсөл дээр ажилласан гэж 9%-ийн нэмэгдэл олгон төслийн захиргааны ажилтан 5 саяас дээш цалин авч байна. - Захиргаа удирдлагын ажилтан, Сургалт судалгаа хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан нарыг туршилтын хугацаагүй томилсон, шууд жинхэлсэн.	Сангийн сайдын 2024.01.23-ны өдрийн 13 дугаартай цалин тогтоох “Маягт шинэчлэх батлах тухай” тушаалыг зөрчсөн.	1. Сангийн сайдын 2024 оны 13 дугаартай “Маягт шинэчлэх батлах тухай” тушаал 2. БОАЖЯ-ны ТНБД-ын 2024 оны А/64 дугаартай “Цалин шинэчлэн тогтоох тухай” тушаал 3. Захиргааны ажилтны сонгон шалгаруулалтад ирүүлсэн материал	 2024.01.23 дугаар 13-Сангийн сайдын  20240229 цалин (1).pdf
2	Төслийн хүрээнд олгосон бартаат замын машины хуваарилалтыг хэрэгцээ шаардлагын судалгаагүй, санхүүжүүлэгч байгууллагад урьдчилан мэдэгдэлгүй өөрчилсөн, төслийн II, III шатанд хамааралгүй байгууллагад давхцуулан олгосон. Авах арга хэмжээ: БОУАӨЯ-ны Өмч хамгаалах зөвлөл тус	- Төслийн II, III шатанд хамааралгүй Төвийн бүсийн, төслийн хүрээнд 2022 онд Ландкрузер автомашин авч байсан Богдхан уулын ДЦГ-т 2024 онд Ниссан Y61 өгсөн. - Төслийн II, III шатанд хамааралгүй Төвийн бүсийн, төслийн хүрээнд 2017 онд Ландкрузер автомашин авч байсан Горхи Тэрэлжийн БЦГ-т 2024 онд Ниссан Y61 өгсөн. - Төслийн II, III шатанд хамааралгүй сонгуулийн 4-р тойрог болох Булган аймгийн	2019.06.26-ны өдөр БОАЖЯ, СЯ, KfW банк хооронд байгуулсан төслийн Тусгай гэрээний 4-т: Төслийн бүтцийг өөрчлөх: “Төслийн бүтцийн аливаа өөрчлөлтөд KfW-аас урьдчилан зөвшөөрөл авахыг шаарддаг бөгөөд үүнд худалдан авалт болон төлбөрийн журмын талаарх томоохон өөрчлөлтүүд орно. Төсөл хэрэгжүүлэх агентлаг нь өөрчлөлтийн тухай KfW-д цаг тухайд нь мэдэгдэж, түүний шалтгаан, төлөвлөсөн арга хэмжээ, үр дагаврыг (нийт зардлыг оролцуулан) мэдэгдэнэ. Ийм арга хэмжээ нь зөвхөн дахин хянагдсан төлөвлөгөө болоод KfW-ийн зөвшөөрөлд үндэслэн хэрэгжиж эхэлнэ.” гэсэн заалтыг зөрчсөн.	4. Бартаат замын машины хуваарилалтыг шинэчилсэн тушаал 5. Бартаат замын машины хуучин хуваарилалтын судалгаа, харьцуулалт 6. БОАЖ-ын сайдын 2024.03.14-ний өдрийн 01/1161 дугаартай албан захидал	https://www.24tsag.mn/a/226311  Хавсралт 1_Бартаат замын машины хув;  Хавсралт 1-1_Бартаат замын  Approved MoM Plan2024.pdf

	асуудлыг хянан шалгаж, давхацсан автомашинуудыг хэрэгцээ шаардлагатай газар нь шилжүүлэн хуваарилах	БОАЖГ-т 2024 онд Ниссан Y61 өгсөн. Төслийн II, III шатанд хамааралгүй сонгуулийн 4-р тойрог болох Хөвсгөл аймгийн Тэс гол Булнайн нурууны БЦГ-т 2024 онд Ниссан Y61 өгсөн. Төслийн II шатны хүрээнд 2022 онд машин авсан Мөнххайрханы БЦГ-т 2024 онд Ниссан Y61 өгсөн.		7. ГСБЗБ-ны албан захидал	
3	Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн бүтцийн сайдын тушаал гараагүй байхад Тусгай гэрээнд заагаагүй албан тушаалтнуудыг 2025 оны 05, 08 дугаар саруудад сонгон шалгаруулсан. Үүний дараа 2024 оны 12 дугаар сард Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн бүтцийн өөрчлөлтийн тухай хоёр сайдын 2024 оны 12 сарын 24-ны өдрийн 236/A/887 дугаартай тушаал гарсан. Авах арга хэмжээ: Тусгай гэрээ, төслийн удирдах хорооны шийдвэрээр баталсан төслийн бүтцийн өөрчлөлтийн дагуу хоёр сайдын хамтарсан тушаал гарган баталгаажуулах. Түүнтэй уялдуулсан ажлын	- Төслийн сургалт мэдээлэл хариуцсан ажилтан 2024 оны 05 сард - Төслийн Хуулийн фирм 2024 оны 08 дугаар сард	Тусгай гэрээний заалтыг зөрчиж огт заагүй албан тушаалтнуудыг сонгон шалгаруулсан. Энэ тушаал нь одоог хүртэл өөрчлөгдөөгүй байна. Тус тушаалыг өөрчлөх талаар дараах шийдвэрүүд гарсан болно. 2024 оны 10-11 дүгээр саруудад хийгдсэн Санхүүжүүлэгч талын хөндлөнгийн үнэлгээгээр өгөгдсөн шаардлага, 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Төслийн удирдах хорооны шийдвэр, болон БОУАӨ-ийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн A/355 дугаартай тушаалын нэгдүгээр хавсралт.	8. Сангийн сайл, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын хамтарсан тушаал 236/A/887	

	байрны тодорхойлолтыг шинэчлэн батлуулах. Хууль бус цалин олгосон учир цалинг нөхөн төлүүлэх.				
4	Хоёр улсын ЗГ-ын гэрээгээр баталгаажсан (20206), 3 орны хэл дээр БОУАӨЯ-ны гадаад хамтын ажиллагааны газраар орчуулагдсан төслийн тусгай гэрээг дахин тендер зарлаж 20 сая төгрөгөөр орчуулуулсан. Авах арга хэмжээ: Хууль бус мөнгө угаасан энэ хэргийг шалгах, холбогдох албан тушаалтан, ажилтан нарт хариуцлага тооцох. Орчуулга хийлгэсэн үндэслэл шаардлагыг нотлох хэрэгтэй.	Тендерийн ажлын даалгавар 2024.03.28-ны өдөр захиалагчаар батлагдсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2024.04.15-ны өдрийн А/149 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийг 2024.04.22-ны өдөр зарлаж, 2024.04.30-ны өдөр хүлээн авч үнэлгээг хийсний дагуу тендерт шалгарсан “Дабль Эл” ХХК-тай 2024.05.14-ний өдөр №24/163 тоот 17,750,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий ажлын гэрээг байгуулсан. Гэрээний дагуу нийт 258 хуудастай 3 баримт бичгийг орчуулахтай холбогдуулан 2024.05.31-ний өдөр эхлэлийн тайланг хүлээн авсан.	- Төслийн үе шат бүрийн хэрэгжилтийн гэрээг ХБНГУ-ын ЗГ, МУ-ын ЗГ-хамтран 2016-2018 онуудад хийсэн. Тус гэрээний төслийн I, II, III үе шат бүрийн гэрээ, тусгай гэрээний заалтыг англи, монгол, герман хэл дээр орчуулан талуудаар баталгаажуулсан.		
5	ТХН-ийн батлагдсан дотоод журмыг дотоод журмыг ажилчдаар хэлэлцүүлэлгүй өөрчилсөн. Авах арга хэмжээ: АБТ-уудыг дахин нягтлах, шаардлагатай тохиолдолд шинэчлэн батлуулах	Ажлын байрны тодорхойлолтыг төслийн хэрэгцээ шаардлагад биш хүнд нь тохируулж өөрчилсөн.	2023-2024 оны тушаал шийдвэр, ирсэн явсан албан бичиг, шинээр баталсан журам, ажлын байрны тодорхойлолт зэрэг төслийн холбогдох баримт бичгүүд нууцлагдмал байдалд байдаг учир төслийн баримт бичигт ХШҮ хийх боломжгүй болсон. Төслийн бичиг баримтыг өгөхгүй байгаа тул ХШҮ хийх боломжгүй байгаа тухай удирдлагад мэдэгдсэн цахим мэйлийг хавсаргав.	9. ТХН-ийн баталсан дотоод журам, АБТ 10. Шинэчилсэн дотоод журам, АБТ	 Дотоод журам.pdf
6	Төслийн IT хариуцсан ажилтныг сольж, ажилчдад урьдчилан			11. Төслийн зөвлөх багийн	

	мэдэгдэлгүйгээр ажлын өрөөнд камер байршуулсан. Авах арга хэмжээ: Төслийн гэрээт IT-хариуцсан ажилтныг солих.			БОННМ-ийн зөвлөхийн тайлан	
7	Төслийн хүрээнд зохион байгуулагдсан тендерийг шалгуулахдаа орчуулгыг ХАА-ны ажилтан нар өөрсдөө хийдэг Авах арга хэмжээ: Тендерийн материалыг албан ёсны орчуулгын байгууллагаар хийлгэх	2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 6.05-д: Төслийн үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн бичиг баримтын мэргэжлийн орчуулга хийлгэх ажлыг төлөвлөсөн ч ХАА-ны ажилтан нар ТББ-аа өөрсдөө орчуулж, санхүүжүүлэгч байгууллагад илгээсэн.	ХАА нарт маш их ачаалал болдог бол нөгөө талаас санхүүжүүлэгч байгууллага шаарддаг.	12. Оноолтоор шалгасан нийт 5 тендерийн жагсаалт	 Approved OP 2024_eng 20240301.

7. ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ САНАЛУУД 11

Тус төсөл нь Санхүүгийн хамтын ажиллагааны төсөл учир техникийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөртэй харьцуулахад бодит хөрөнгө оруулалт хийдгээрээ онцлог юм.

1. Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний баталгаажсан хугацааг харвал сүүлийн 3 жилд ихэвчлэн эхний улирал, болон хагас жилд захиалагч санхүүжүүлэгч талуудаар баталгаажиж байна. Энэ нь үйл ажиллагаа төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх, он дамжих, цуцлагдах эрсдэл үүсгэж байна. Иймд төслийн YAT-ны төсөл саналыг урьд оны 11 сар гэхэд боловсруулж талуудад хэлэлцүүлдэг албан хугацаатай болох хэрэгтэй.
2. Захиалагч талтай ажлын уялдаа холбоог сайжруулах талаар нэгдсэн шийдэлд хүрч батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлдэг байх хэрэгтэй.
3. YAT-ны концепци боловсруулахын өмнө хийх ажлын саналыг суурь судалгаа, хэрэгцээ шаардлагын үндэслэл, захиалагч талуудын санал нэгдсэн албан хүсэлт зэргийг үндэслэн олон талт хэлэлцээрийн дараа баталгаажуулдаг байх. Энэ нь төлөвлөлтийг үр дүнтэй, олон нийтэд хүртээмжтэй, зорилтот бүлгүүдэд хүрэх дам нөлөөгөөр төслийн зорилго чиглэлтэй уялдсан байх боломжийг бүрдүүлэх юм.
4. Төслийн YAT-г боловсруулахдаа шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг зааж өгсөн индикатортай уялдуулах хэрэгтэй.
5. Санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж байгаа төслийн хувьд худалдан авах ажиллагаа, түүний бэлтгэл ажил болох хэрэгцээ шаардлагын судалгаа хийх, техникийн тодорхойлолт, тендерийн бичиг баримт, ажлын даалгаврыг боловсруулах болон ХАА-ны үр дүнд байгуулагдах ажил, бараа, зөвлөх үйлчилгээ нийлүүлэх ажлын гэрээ, тэдгээрийн хэрэгжилт зэрэг нь төслийн үйл ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэнэ. Иймд ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг мэргэжлийн багаар тодорхойлуулах, тус ажлыг төрийн тухайн чиглэлийн байгууллагуудаар хянуулдаг байх шаардлагатай. Жишээ нь: Барилга, зураг төсөл, машин, тоног төхөөрөмж, хувцас хэрэглэл.
6. Төслийн санхүүжүүлэгч байгууллага болох Германы Сэргээн босголт, зээлийн (KfW) банкны 2024 оны үнэлгээний багаас төслийн стратегийн чиг баримжаа дутмаг байгаагаас цогцоор нь өөрчлөхөөс гадна тогтвортой үр дүн, нөлөөллийн талаар тодорхой анхаарал хандуулалгүйгээр богино хугацааны арга хэмжээ, түр зуурын хэрэгцээнд ихээхэн анхаарал хандуулж байгааг онцлон тэмдэглэсэн. Хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө ТХГН-уудын менежмент төлөвлөгөөтэй уялдуулан, ТХГН-ийн хэрэгцээ шаардлага дээр үндэслэсэн байх шаардлагатай. Тус хэрэгцээ шаардлагыг чиглэлийн дээд байгууллага хянан үзэж, тоо ширхэг, нийцлийг баталгаажуулан албан ёсоор төслийн зөвлөх баг, ТХН-д ирүүлдэг байх шаардлагатай. Энэ нь үйл ажиллагааны төлөвлөлтийг бодитой хэрэгжүүлэх, үнэлэх дүгнэхэд цаашлаад хүртээмжтэй хуваарилах, чиг үүргийн дээд байгууллага, ЗГ-ын алсын хараа, дунд хугацааны төлөвлөлтөд нийцэх, уялдах боломжтой юм.
7. Төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж хурдан хугацаанд зөв зохистой менежментээр төлөвлөх цаашлаад төсөл дууссанаас хойш тогтвортой, урт хугацааны хөрөнгө оруулалт болгож үлдээх нь хугацаа чухал гэж үзэж байна. Иймд YAT нь төслийн хэрэгжилтийн үр ашгийг баталгаажуулахын тулд жижиг хэмжээний худалдан авалтаас илүүтэй томоохон, чухал үйл ажиллагаа руу төвлөрөх нь зүйтэй.

8. Төслийн хүрээнд үйл ажиллагааг ил тод байлгаж, төслийн зөвлөх баг болон бусад холбогдох талуудыг оролцуулах, шийдвэрийг хамтран гаргах, ТХН, ЗБ-ийн хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах байнгын бөгөөд олон талт харилцаатай байх, мөн KfW-д урьдчилан мэдэгдсэн байх ёстойг санхүүжүүлэгч тал анхааруулсан болно.
9. Төслийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө оройтож баталгаажсан, одоогоор хэрэгжилтийг бүрэн үнэлэх боломжгүй байна. Төслийн үйл ажиллагаа, худалдан авалтын төлөвлөгөөний төслийг урд оны 11 сарын 30 гэхэд боловсруулж талуудад танилцуулдаг, 12 сарын 15-20 гэхэд баталгаажуулдаг тогтсон хугацааг захиалагч тал, санхүүжүүлэгч тал, хэрэгжүүлэгч нэгжүүд хэлэлцэж батлах шаардлагатай юм.

БОЛОВСРУУЛСАН:

ТӨСЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АЖИЛТАН



Г.САЙНБАЯР

оны 06 дугаар сарын 30-ны өдөр